



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2014 оны 09 сарын 26 өдөр

Дугаар 319

Улаанбаатар хот

Заавар батлах тухай

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх заалт, Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай 2012 оны 120 дугаар тогтоолын “Эрүүл чийрэг Монгол хүн” хөтөлбөрийн 168.3 дэх заалтын биелэлтийг хангах зорилгоор ТУШААХ НЬ:

1. Сүрьеэгийн тусламж үйлчилгээний удирдлага, зохион байгуулалтын зааврыг нэгдүгээр, эмэнд мэдрэг сүрьеэгийн тусламж, үйлчилгээний зааврыг хоёрдугаар, эмэнд тэсвэртэй сүрьеэгийн тусламж, үйлчилгээний зааврыг гуравдугаар, Сүрьеэ, ХДХВ/ДОХ-ын хавсарсан халдварын тусламж, үйлчилгээний зааврыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Зааврын хэрэгжилтийг улсын хэмжээнд удирдан зохион байгуулахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Я.Буянжаргал), мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж хэрэгжилтийг ханган ажиллахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв (Д.Нямхүү)-д тус тус үүрэг болгосугай.

3. Үндэсний хэмжээнд шаардлагатай сүрьеэгийн эм, урвалж бодисыг хүлээн авахтай холбогдон гарах зардлыг хариуцан ажиллахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв (Д.Нямхүү), хуваарилагдсан эм, урвалж бодис татан авахад зарцуулах тээврийн зардлыг хариуцахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, нэгдсэн эмнэлгийн дарга нарт тус тус даалгасугай.

4. Холбогдох хүний нөөцийг бэлтгэн мэргэшүүлэх ажлыг удирдан зохион байгуулахыг Төрийн захиргааны удирдлагын газар (Д.Оюунчимэг)-т даалгасугай.

5. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн хэлтэс (Я.Амаржаргал), Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (С.Төгсдэлгэрт)-т тус тус даалгасугай.

6. Энэ тушаал гарсантай холбогдуулан “Сүрьеэгийн тусламж үйлчилгээний удирдамж батлах тухай” Эрүүл мэндийн сайдын 2009 оны 397 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Н.УДВАЛ

D:\barimt\tushaal
082085

2

Эрүүл мэндийн сайдын 2014 оны
09 сарын 26 өдрийн 319 дугаар
тушаалын 1 дүгээр хавсралт

СҮРЬЕЭГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЗААВАР

1. Халдварт өвчин судлалын үндэсний төв

- 1.1 “Халдварт өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр”, “Сүрьеэтэй тэмцэх, сэргийлэх үндэсний стратеги” төлөвлөгөөний хэрэгжилтийг удирдан зохион байгуулах; урьдчилан сэргийлэх арга хэмжээг улсын хэмжээнд төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх, сүрьеэгийн өвчлөл, тархалт, тандалт, сүрьеэгийн оношилгоо, эмчилгээ, эмнэлзүйн удирдамж, заавар, стандарт, аргачлал, боловсруулах; эмч, эмнэлгийн мэргэжилтнийг давтан сургах, мэргэшүүлэх; эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх; сүрьеэгийн чиглэлээр тусламж үйлчилгээ үзүүлж буй эрүүл мэндийн байгууллагууд, сүрьеэгийн хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх, дэмжлэгт хяналт хийж мэргэжил арга зүйн зөвлөмжөөр ханган ажиллана;
- 1.2 Нийгмийн эрүүл мэндийн байгууллагуудтай урьдчилан сэргийлэх, тандалт судалгаа, болон бусад чиглэлээрх үйл ажиллагааг эрчимжүүлэн бүх түвшинд зохион байгуулан ажиллана;
- 1.3 Сүрьеэгийн оношилгоо, эмчилгээний тоног төхөөрөмж, лабораторийн урвалж бодис, оношлуур, эмийн нөөц, эмийн хэрэгцээг тодорхойлох, захиалах, хүлээн авах, хадгалах, хуваарилах, үндэсний хэмжээнд эм, оношлуур, сүрьеэгийн сорьц тээвэрлэх, өдрийн эмчилгээний цэгт шаардагдах хэрэгцээг судалгаанд үндэслэн жил бүрийн төсвийн төслийн санхүүжилтийг төлөвлөнө;
- 1.4 Сүрьеэгийн цахим мэдээллийн үндэсний сүлжээг тогтмол шинэчлэх, тогтвортой үйл ажиллагааг хангах, мэдээллийн санг бүх түвшинд ашиглах боломжийг бүрдүүлэх, шаардлагатай цахим сүлжээтэй уялдуулан ажиллана.

2. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар

- 2.1 “Халдварт өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр”, “Сүрьеэтэй тэмцэх, сэргийлэх үндэсний стратеги” төлөвлөгөөг орон нутгийн өвчлөл, хүн амын тоо бусад онцлогыг тусган боловсруулж нутгийн өөрөө удирдах дээд байгууллагаар батлуулан, санхүүжилтийг шийдвэрлүүлэн, хэрэгжилтийн тайланг дүгнэн шаардлагатай арга хэмжээг төлөвлөн ажиллана;
- 2.2 Хүн амын дунд сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааг тогтмол зохион байгуулах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд үнэлгээ, дүгнэлт хийх, орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллага, төрийн ба төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран ажиллана;

- 2.3 Эмч, эмнэлгийн мэргэжилтэнг сүрьеэгийн чиглэлээр мэргэжил олгох, дээшлүүлэх сургалтад хамруулах, хүний нөөцийн тасралтгүй үйл ажиллагаа, ажлын байрны сургалтыг төлөвлөн зохион байгуулна;
- 2.4 Сүрьеэгийн тусламж, үйлчилгээнд зайлшгүй шаардлагатай эм, эмийн нөөц, урвалж бодис, оношлуур, сүрьеэгийн сорьц тээвэрлэх, лабораторийн болон халдвар хяналтын тоног төхөөрөмж, анхан шатны маягт, сургалт, сурталчилгааны материал, өдрийн эмчилгээний цэгийн санхүүжилтийг жил бүрийн төсөвт тусгах, захиалах, татан авах, хадгалах, хувиарлах, түгээх, хянах ажлыг удирдан зохион байгуулна;
- 2.5 Сүрьеэгийн цахим мэдээллийн үндэсний сүлжээ, түүний мэдээлэл, тоног төхөөрөмж, бэлтгэгдсэн хүний нөөцийн тогтвортой байдлыг хангаж ажиллана;
- 2.6 Энэрэл эмнэлэг, бусад ижил төстэй үйл ажиллагаа бүхий байгууллагыг дэмжих, байр болон бусад зардлыг жил бүрийн төсөвт тусгах, санхүүжилтийг нэмэгдүүлэх судалгаа тооцоололтыг хийж шийдвэрлүүлнэ.

3. Аймаг, дүүргийн сүрьеэгийн кабинет

- 3.1 "Нэгдсэн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагааны стандарт" MNS 5095:2013 дагаж мөрдөнө;
- 3.2 Орон нутгийн хүн амын дунд сүрьеэгийн чиглэлээр тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, сүрьеэд өртөх эрсдэл өндөртэй бүлгийн хүмүүсийн судалгаа гаргах үйл ажиллагааг зохион байгуулахад тэргүүлэх үүрэгтэй оролцоно;
- 3.3 Урьдчилан сэргийлэх, тандалт судалгаа болон бусад чиглэлээр нийгмийн эрүүл мэндийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллана;
- 3.4 Хүн амын дунд сүрьеэ өвчнээс сэргийлэх үйл ажиллагаа, ялгаварлан гадуурхалтыг бууруулах мэдээлэл, сургалт сурталчилгааг тогтмол явуулж, үр нөлөөний үнэлгээ хийж, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, дадал болгон хэвшүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллана;
- 3.5 Халдвартай сүрьеэгээр өвчилсөн насанд хүрэгсэд, бүх хэлбэрийн сүрьеэгээр өвчилсөн хүүхдийн хавьтлын судалгааг насанд хүрэгчдэд (жирэмсэн эмэгтэйгээс бусад тохиолдолд) рентген шинжилгээ, шаардлагатай тохиолдолд цэрний түрхцийн шинжилгээ хийх; 15 хүртэлх насны хүүхдүүдэд туберкулины сорил тавьж үзлэг шинжилгээнд хамруулах аргаар хийнэ;
- 3.6 Сүрьеэгийн чиглэлээр эмч, мэргэжилтнүүдэд сургалтыг зохион байгуулна;
- 3.7 Сүрьеэгийн тусламж үйлчилгээнд зайлшгүй шаардлагатай эм, эмийн нөөц, урвалж бодис, оношлуур, сүрьеэгийн сорьц тээвэрлэх, лабораторийн болон халдвар хяналтын тоног төхөөрөмж, анхан шатны маягт, сургалт, сурталчилгааны материалын санхүүжилтийг жил бүрийн төсөвт тусгах, захиалах, татан авах, хадгалах, хуваарилах болон түгээж, хянана;
- 3.8 Сүрьеэ өвчтэй хүний хөдөлмөрийн чадвар түр алдалтын тогтоох асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлүүлнэ;
- 3.9 Өдрийн эмчилгээний цэгийн үйл ажиллагаанд үнэлгээ хийж, үйл ажиллагааг сайжруулна;

- 3.10 Сүрьеэгийн мэдээ, тайлан, үнэлгээ, судалгааны дүнг холбогдох байгууллагад цаг хугацаанд нь илгээх, орон нутгийн удирдлагуудыг мэдээллээр хангаж, хариу арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- 4. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг**
- 4.1 Сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх, ялгаварлан гадуурхалтыг бууруулах тандалт судалгаа, мэдээлэл, сургалт сурталчилгааг тогтмол явуулж, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, дадал болгон хэвшүүлэхэд бусад байгууллага, иргэдтэй хамтран ажиллана;
- 4.2 Сүрьеэгийн мэдээ, тайланг холбогдох байгууллагад хугацаанд нь илгээх, орон нутгийн удирдлагуудыг мэдээллээр хангана;
- 4.3 Тухайн орон нутгийн хүн амын дунд сүрьеэгийн чиглэлээр тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхдээ бусад байгууллагатай хамтарч ажиллана.
- 5. Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд**
- 5.1 Сүрьеэгийн сэжигтэй үйлчлүүлэгчээс сорьц авч өөрийн лабораторид шинжлэн оношийг тогтоох, шинжилгээ хийх боломжгүй үед үйлчлүүлэгч эсвэл сорьцыг ХӨСҮТ-ийн сүрьеэгийн лавлагаа лабораторид илгээж онош баталгаажуулна;
- 5.2 Сүрьеэгийн онош батлагдсан өвчтөнийг харьяа аймаг, дүүргийн сүрьеэгийн амбулаторит илгээх ба онош эргэлзээтэй болон хүнд өвчтөнийг эмнэлэг хооронд эмч дуудаж зөвлөгөө авах журмын дагуу ХӨСҮТ-өөс эмч дуудан зөвлөгөө авч онош тодруулна.
- 6. Энэрэл эмнэлэг**
- 6.1 Эрсдэл өндөртэй үйлчлүүлэгчдийн дунд сүрьеэ илрүүлэх үзлэг, шинжилгээг тогтмол зохион байгуулж, эмнэлгийн тусламж, үйлчилгээг чанартай хүргэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэн үр дүнг тооцон ажиллана;
- 6.2 Энэрэл эмнэлэг нь жил бүр шаардлагатай байгаа хүний нөөц, эм, оношлуур, тоног төхөөрөмж болон бусад зардлыг төсвийн төсөлд тусгах саналыг Нийслэлийн эрүүл мэндийн газарт хүргүүлж шийдвэрлүүлнэ;
- 6.3 Сүрьеэгийн мэдээ, тайланг холбогдох байгууллагад хугацаанд нь илгээнэ.
- 7. Хорих анги**
- 7.1 Хорих ангийн эмч, мэргэжилтнүүд сүрьеэгийн чиглэлээр мэдлэг, мэргэшлээ байнга дээшлүүлж, сургалтад хамрагдаж, сүрьеэгийн тусламж, үйлчилгээний зааврыг баримтлан ажиллана;
- 7.2 Хорихын сүрьеэгийн өвчлөлийн тайланд сар улирал бүр дүгнэлт хийж, хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, сүрьеэгийн мэдээ, тайланг холбогдох байгууллагад хугацаанд нь илгээнэ;
- 7.3 Хорих 429 дүгээр ангийн эмнэлэгт сүрьеэтэй эмчлүүлж байсан ялтан суллагдсан тохиолдолд сүрьеэтэй өвчтөнг харьяа орон нутагт шилжүүлж эмчилгээ таслахаас сэргийлэх арга хэмжээг авна.

8. Хувийн хэвшлийн эмнэлгүүд

- 8.1 Сүрьеэгийн сэжигтэй үйлчлүүлэгчдээс сорьц авч өөрийн лабораторид шинжлэн оношийг тогтоох, шинжилгээ хийх боломжгүй үед үйлчлүүлэгчийг болон сорьцыг харьяаллын дагуу сүрьеэгийн лабораторид илгээнэ;
- 8.2 Сүрьеэгийн онош батлагдсан өвчтөнийг харьяа аймаг, дүүргийн сүрьеэгийн амбулаторит илгээх ба онош эргэлзээтэй болон хүнд өвчтөнийг эмнэлэг хооронд эмч дуудаж зөвлөгөө авах журмын дагуу эмч, мэргэжилтэнг дуудан зөвлөгөө авч онош тодруулна;
- 8.3 Сүрьеэгийн онош батлагдсан өвчтөний биеийн байдлыг харгалзан биеийн байдал хүнд байвал тухайн эмнэлэг өвчтөний биеийн байдал тогтворжтол мэргэжлийн эмчийн зөвлөмжийн дагуу эмчилгээг хийж зохих журмын дагуу шилжүүлнэ.

СҮРЬЕЭГИЙН ЭРТ ИЛРҮҮЛЭГ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

1. Халдварт өвчин судлалын үндэсний төв

- 1.1 Халдварт өвчин судлалын үндэсний төв нь сүрьеэ өвчний эрт илрүүлэг, оношилгоо, эмчилгээний тусламж, үйлчилгээг үндэсний хэмжээнд удирдан зохион байгуулж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллана;
- 1.2 Нийт хүн амын дунд сүрьеэ өвчний тандалт судалгаа, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг тогтмол оновчтой зохион байгуулах үр дүнгийн үнэлгээг хийх;
- 1.3 Эрсдэл өндөртэй үйлчлүүлэгчдийн дунд сүрьеэ эрт илрүүлэг үзлэг, шинжилгээг төлөвлөн тогтмол зохион байгуулж, оношилгоо, эмчилгээнд хамруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч бусад байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ;
- 1.4 Сүрьеэ өвчтэй хүний хавьтал илрүүлэлт, тандалт судалгааг тогтмол хийж, үр дүнг тооцож, төлөвлөгөө боловсруулан ажиллана;
- 1.5 Хорих ангийн сүрьеэ өвчтэй хоригдолд үзүүлж буй тусламж, үйлчилгээг хянах, үнэлэх зөвлөмж өгөх, эмч, мэргэжилтнүүдийг мэргэжил арга зүйгээр хангаж ажиллана;
- 1.6 Сүрьеэгийн нян судлал, молекул биологи, өсгөвөрлөх шинжилгээнүүдийг чанарын өндөр түвшинд гүйцэтгэх, сүлжээ лабораторийн оношилгоо, шинжилгээний гадаад болон дотоод хяналтыг тогтмолжуулна;
- 1.7 Эрүүл мэндийн байгууллагаас илгээсэн өвчтөнд сүрьеэгийн тусламж, үйлчилгээг шуурхай, мэргэжлийн өндөр түвшинд үзүүлнэ.

2. Аймаг, дүүргийн сүрьеэгийн кабинет

- 2.1 Сүрьеэгийн сэжигтэй тохиолдол бүрийг оношилж, онош батлагдсан сүрьеэг бүртгэнэ. Бүртгэгдсэн тохиолдолд биеийн байдал, өвчний явц болон үйлчлүүлэгчийн саналд үндэслэн шууд хяналттай эмчлэх эмчилгээний явцад

хяналтын шинжилгээг товлосон хугацаанд нь хийж, хавьтал илрүүлэлт, тандалт судалгаа хийнэ;


- 8.4 Сүрьеэгээр өвчлөх эрсдэлт бүлгийн хүн амын дунд сүрьеэ илрүүлэх идэвхтэй үзлэг шинжилгээ хийх, эрт оношлох, хавьтлыг судлах, тандах, эмчлэх арга хэмжээг удирдан зохион байгуулж, дэмжлэгт хяналт хийн зөвлөмж хүргүүлэн, биелэлтийг хянан ажиллана;
- 2.2 Түр оршин суугч, тодорхой хаяггүй сүрьеэтэй өвчтөнг оршин суугаа газрын эрүүл мэндийн байгууллага бүртгэн авч, тусламж үйлчилгээг үзүүлж, эмчилгээг таслахгүй байхад анхааран гэр бүлийн гишүүд, орон нутгийн удирдлага, бусад байгууллага, иргэдтэй хамтран ажиллана;
- 2.3 Сүрьеэтэй өвчтөн болон тэдний гэр бүлийн гишүүдэд сүрьеэгийн талаар зөвлөгөө, мэдээлэл өгнө;
- 2.4 Өдрийн эмчилгээний цэгт үйлчлүүлэгч нарт эмчилгээ, зөвлөгөөг өдөр тутам өгөх, бусдад халдвар тараахгүй байх дадлыг сургах, чанартай үйлчилгээг үзүүлнэ;
- 2.5 Эмэнд мэдрэг сүрьеэтэй өвчтөний хавьтлыг жилд нэг удаа, 5 жилийн турш, эмэнд тэсвэртэй сүрьеэтэй өвчтөний хавьтлыг эхний 2 жилд 6 сар тутам, хойшид жилд нэг удаа сүрьеэгийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, нийт 5 жил хянах, туберкулины сорилын хариу урвалын тайлан мэдээг хүргүүлэх, урьдчилан сэргийлэх эмчилгээ хийх ажлыг сүрьеэгийн болон тархвар судлаач, нийгмийн ажилтантай хамтран зохион байгуулна;
- 2.6 Жирэмсний эхний болон II-р хагаст сүрьеэ илрүүлэхдээ асуумж авч, сэжигтэй тохиолдолд сүрьеэгийн эмчид илгээж, шаардлагатай тохиолдолд бусад шинжилгээг хийнэ.
- 2.7 Жирэмсэн эмэгтэйд сүрьеэ өвчнийг илрүүлэх, оношлох рентген шинжилгээг хийх зайлшгүй шаардлагатай тохиолдолд жирэмсний хяналтын эмч болон сүрьеэгийн эмчийн хамтарсан шийдвэрийг үндэслэн үйлчлүүлэгчид заавал тугалган хаалтаар хамгаалалт хийж шинжилнэ.


3. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг

- 3.1 Сүрьеэтэй өвчтөний эмчилгээг зааврын дагуу шууд хяналттай хийж, хяналтын үзлэг, шинжилгээнд хугацаанд нь хамруулна;
- 3.2 Сүрьеэгийн сэжигтэй тохиолдлоос 2 удаагийн цэрний сорьц авч сүрьеэгийн лабораторид илгээнэ;
- 3.3 Жирэмсний эхний болон II-р хагаст сүрьеэ илрүүлэхдээ асуумж авч, сэжигтэй тохиолдолд сүрьеэгийн эмчид илгээж, шаардлагатай тохиолдолд бусад шинжилгээг хийнэ.
- 3.4 Нярайд хийсэн БЦЖ вакцины урвал хүндрэл, сорвижилтыг 1, 3, 12 сартайд нь үнэлэн эрүүл мэндийн дэвтэрт тэмдэглэж, хэрэв сорви үүсээгүй бол туберкулины сорил тавьж сөрөг тохиолдолд нөхөн дархлаажуулалтад хамруулна.

4. Энэрэл эмнэлэг

- 4.1 Гэр оронгүй, тодорхой оршин суух хаяггүй сүрьеэтэй өвчтөнд сүрьеэгийн тусламж үйлчилгээг 6-8 сар шууд хяналттай хийнэ;
- 4.2 Эмчилгээний явцад гарч болох хүндрэл, түүнээс сэргийлэх арга хэмжээг авна;
- 4.3 Сүрьеэтэй өвчтөнд сүрьеэгийн эмчилгээ, эмийн гаж нөлөө, илэрч болох шинжүүд, эмчилгээний явцад гарч болох хүндрэл болон эмчилгээ таслахгүй байх, бусдад халдварыг тараахгүй байх талаар зөвлөгөө өгнө;





ЭМЭНД МЭДРЭГ СҮРЬЕЭГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗААВАР

1. Тодорхойлолт, нэр томьёо

Сүрьеэ

Сүрьеэгийн нян (*Mycobacterium tuberculosis complex*)-гаар үүсгэгдсэн, агаар дуслын замаар дамжин халдварладаг халдварт өвчин.

Сүрьеэгийн үүсгэгч

Сүрьеэгийн үүсгэгч нь (*Mycobacterium tuberculosis complex*) нян

Халдварын эх уурхай

Уушгины халдвартай хэлбэрийн сүрьеэтэй хүн

Сүрьеэгийн нянгийн халдвартай хүн

Сүрьеэгийн шинж тэмдэггүй, туберкулины сорил эерэг, сүрьеэгийн бусад шинжилгээнд өөрчлөлтгүй, бусдад халдвар тараахгүй.

Сүрьеэгийн халдварын голомт

Сүрьеэгийн халдварын эх уурхай, өртөмхий бие махбодь, дамжих замыг нэгтгэн сүрьеэгийн голомт гэнэ.

Сүрьеэгийн ойрын хавьтал

Өвчтөн оношлогдох үед болон оношлогдохоос өмнө 3 сараас дээшгүй хугацаагаар хамт амьдарч байгаа гэр бүлийн гишүүд

Сүрьеэгийн халдварт өртөх эрсдэл өндөртэй бүлэг

- Сүрьеэтэй өвчтөний ойрын хавьтал
- ХДХВ-ийн халдвартай хүмүүс
- Архи, мансууруулах бодист донтогсод
- Халдвар тархах эрсдэл өндөртэй орчинд ажиллаж, амьдарч буй хүн (асрамжийн газар, сэтгэцийн эмнэлэг, хорих анги, түр саатуулах байр, орон гэргүй хүмүүсийн түр орогнох байр)
- Эрсдэл өндөртэй үйлчлүүлэгчдэд тусламж, үйлчилгээ үзүүлж буй эрүүл мэндийн сайн дурын идэвхтэн
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ хүртэж чадахгүй, нэн ядуу, тодорхой оршин суух хаяггүй, орон гэргүй иргэд
- Жирэмсэн эмэгтэй

Сүрьеэгийн тохиолдлын индекс

Тухайн голомтонд анх удаа өвчилсөн тохиолдлыг хэлнэ.

Туберкулины сорил

Сүрьеэгээр өвчилснийг оношлохгүй, сүрьеэгийн нянгаар халдварлагдсан эсэхийг тодорхойлно.

Сүрьеэгийн өвөрмөц урьдчилан сэргийлэлт.

Сүрьеэгийн эсрэг дархлаажуулалт



БЦЖ вакцины дараах хэсэг газрын урвал

Нярайд вакцин тарьсан хэсэг газарт 2-4 долоо хоног өнгөрсний дараах өвөрмөц урвал

Халдвар хяналт

Эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагад эмнэлгээс шалтгаалсан халдвар тархахаас сэргийлэхэд чиглэгдсэн тохиолдлыг эрт илрүүлж, хариу арга хэмжээг шуурхай хэрэгжүүлэх замаар үйлчлүүлэгчдэд аюулгүй, чанартай тусламж, үйлчилгээ үзүүлэх зорилго бүхий зохион байгуулалтын болон халдвараас сэргийлэх иж бүрдэл арга хэмжээ

Эмнэлгээс шалтгаалсан сүрьеэгийн халдвар

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний явцад халдвартай хэлбэрийн сүрьеэтэй өвчтөнөөс сүрьеэгийн нян бусад өвчтөн, эмч, эмнэлгийн ажилтанд халдварлах

Эмэнд мэдрэг сүрьеэ

Сүрьеэгийн эмэнд мэдрэг нянгаар үүсгэгдсэн өвчин

Эмэнд тэсвэртэй сүрьеэ

Сүрьеэгийн эмэнд тэсвэртэй нянгаар үүсгэгдсэн өвчин

Уушгины сүрьеэгийн сэжигтэй тохиолдол

14 хоног ба түүнээс дээш хугацаагаар ханиалгаж байгаа хүн

Нян судлалын шинжилгээгээр батлагдсан сүрьеэгийн тохиолдол

Биологийн сорьц (Цэр, шээс, өтгөн, гялтангийн болон хэвлийн хөндийн шүүдэс, ходоодны угаадас, мэс заслын эд зэрэг)—нд хийсэн түрхэцийн, өсгөвөрлөх эсвэл молекул биологийн шинжилгээгээр (Жене эксперт) сүрьеэгийн нян илэрсэн тохиолдол

Эмнэлзүйгээр оношлогдсон сүрьеэгийн тохиолдол

Нян судлалын шинжилгээгээр батлагдаагүй боловч эмнэлзүйгээр оношлогдсон сүрьеэ; гэрлийн шинжилгээ, эд эсийн болон бусад шинжилгээгээр илэрсэн өөрчлөлтөд үндэслэн оношилсон уушгины ба уушгины бус эрхтэний сүрьеэ

Хэрэв эмчилгээний явцад нян судлалын шинжилгээгээр сүрьеэгийн нян илэрвэл нян судлалаар батлагдсан сүрьеэ

Бактек автомат машин

Микобактерийн ургалтыг илрүүлэх, M. tuberculosis-ийн эмийн мэдрэг чанар тодорхойлох зорилготой радиометрийн бус, бүрэн автомат машин

Шинэ тохиолдол

Сүрьеэгийн эмчилгээ хийлгэж байгаагүй эсвэл сүрьеэгийн эмийг 1 сар хүртэлх хугацаанд хэрэглэж байсан.

Өмнө нь эмчлэгдэж байсан тохиолдол

Өмнө нь 1 сараас дээш хугацаагаар сүрьеэгийн эм ууж байсан

Дахисан тохиолдол

Сүрьеэгийн эмчилгээг амжилттай дуусгасан боловч дахин сүрьеэгээр өвчилсөн

Эмчилгээ үр дүнгүй болсны дараах тохиолдол

Сүрьеэгийн эмчилгээний хяналтын 5 болон түүнээс дээш сард түрхэц эерэг байгаа, эмчилгээ дахин эхэлсэн

Эмчилгээ тасалсны дараах тохиолдол

Сүрьеэгийн эмчилгээг 2 сар ба түүнээс дээш хугацаагаар орхисны дараа эмчилгээ дахин эхэлсэн

Эдгэрсэн тохиолдол

Нян судлалын шинжилгээгээр батлагдсан уушгины сүрьеэтэй өвчтөн эмчилгээний сүүлийн саруудад 2 удаа дараалан хийсэн түрхцийн шинжилгээ сөрөг болох

Эмчилгээ дуусгасан тохиолдол

Эмчилгээ бүрэн хийлгэсэн, эмчилгээ үр дүнгүй болсон нь нотлогдоогүй боловч хяналтын сүүлийн саруудын шинжилгээ бүрэн хийгдээгүй

Үр дүнгүй тохиолдол

Нян судлалын шинжилгээгээр батлагдсан уушгины сүрьеэгийн тохиолдол эмчилгээний 5 дахь эсвэл сүүлийн сард түрхэц эерэг байх; эмнэл зүйгээр батлагдсан уушгины сүрьеэгийн тохиолдол эмчилгээний 2 дахь сард эсвэл үргэлжлэх шатны эмчилгээний явцад түрхэц эерэг болох

Хяналт алдагдсан тохиолдол

Бүртгэгдсэн боловч эмчилгээнд хамрагдаагүй сүрьеэ; эмчилгээ дараалан 2 ба түүнээс дээш сар таслах

Нас баралт

Сүрьеэгийн эмчилгээний явцад нас барсан тохиолдол

Шилжсэн тохиолдол

Сүрьеэгийн эмчилгээний явцад шилжсэн

**2. Сүрьеэ илрүүлэлт, шинжилгээ**Хүснэгт 1. Илрүүлэх аргууд

Идэвхитэй	Хүн амын дунд зориудын урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулах
Идэвхигүй	Эмнэлэгт хандсан үйлчлүүлэгчдийн дундаас сүрьеэгийн сэжигтэй тохиолдлыг оношлох
Хагас идэвхитэй	Сүрьеэгээр өвчлөх эрсдэл өндөртэй хүн амын дунд сүрьеэгийн урьдчилан сэргийлэх үзлэг хийх

Хүснэгт 2. Оношилгооны аргууд

Шууд	Шууд бус
Түрхэцийн, өсгөвөрлөх, молекул биологи, эд эсийн шинжилгээнүүд,	Рентген шинжилгээ, туберкулины сорил, иммунологийн арга, дурангийн шинжилгээнүүд

2.1 Түрхцийн шинжилгээ

Сорьцоос наалдац бэлдэж Циль-Нильсены эсвэл Аурамыны аргаар будаж бичил харуураар шинжилнэ. Хүчилд тэсвэртэй нян илэрвэл "түрхэц эерэг", илрээгүй тохиолдолд "түрхэц сөрөг" гэж тодорхойлно.

2.2 Өсгөвөрлөх шинжилгээ

- Хатуу тэжээлт орчинд өсгөвөрлөх: Сорьцонд зааврын дагуу жигдлэн боловсруулалт хийж 2%-ийн (Огава, Левенштэйн-Иенсений) хатуу тэжээлт орчинд тарьж +37°C-ийн хэмд 8 долоо хоног хүртэл ургуулан нянгийн ургалтыг долоо хоног тутам шалган 28-56 хоногт хариуг мэдээлнэ. Шинжилгээний хариуг **эерэг, сөрөг, бохирдсон** гэж дүгнэнэ.
- Шингэн тэжээлт орчинд өсгөвөрлөх: Сорьцыг (Мидллебрук 7Н9 суурьтай) шингэн тэжээлт орчинд тарьж, Бактек автомат машинд өсгөвөрлөж 5-42 хоногийн дотор хариуг мэдээлнэ.
- Шинжилгээний хариуг **эерэг, сөрөг, бохирдсон** гэж дүгнэнэ.

2.3 Эд, эсийн шинжилгээ

Үрэвсэлт өөрчлөлттэй эрхтэнээс авсан сорьцонд эд, эсийн шинжилгээ хийж өвөрмөц үрэвслийн шинжийг илрүүлнэ. Оношилгооны зорилгоор авсан жижиг эдийг 3-5 хоногт, мэс заслын тайралт хийж авсан эдийг 5-10 хоногт тодорхой журмын дагуу анх шинжилгээнд сорьц ирүүлсэн эрүүл мэндийн байгууллагад хариуг хугацаанд нь илгээж хамтарч ажиллана.

2.4 Молекул биологийн шинжилгээ

Сүрьеэгийн үүсгэгчийг нуклейн хүчлийн олшруулалтын аргаар илрүүлж буй аргыг хэлнэ. Шинжилгээний үр дүн тухайн сорьцонд сүрьеэгийн үүсгэгч **илэрсэн** эсвэл **илрээгүй** гэсэн хариу гарна

Жене Экспертийн арга

Жене Эксперт нь бодит хугацааны полимерагийн гинжин урвалд суурилагдсан нэгэн зэрэг сүрьеэгийн үүсгэгч болон рифампицины тэсвэржилтийг 2 цагийн дотор илрүүлдэг, гар ажиллагаа багатай молекул биологийн арга юм. Цэрний сорьцонд шинжилгээ хийх боломжтой.

Хайн тестийн арга

Олон эмэнд тэсвэртэй сүрьеэг оношлох хурдавчилсан оношилгооны арга

Изониазид, рифампициний тэсвэржилтийг тодорхойлох молекул генетикийн шинжилгээ

Энэ шинжилгээ нь сүрьеэгийн нянгийн ДНХ ялгах, полимерагийн гинжин урвал (ПГУ), ДНХ гибридүүлгийг ашиглаж сүрьеэгийн эсрэг эм изониазид, рифампицинд тэсвэртэй мутантыг илрүүлэх гэсэн 3 шаттай явагдана. Сүрьеэгийн үүсгэгчийн генотип, эмэнд тэсвэртэй мутантыг тодорхойлох зааврыг ашиглаж шинжилгээний үр дүнд изониазид, рифампицинд мэдрэг эсвэл тэсвэртэй гэсэн үнэлгээ өгнө.

2.5 Рентген шинжилгээ

Сүрьеэгийн оношилгоонд эгц болон хажуу зураг авна.

2.6 Туберкулины сорил

Сүрьеэгийн нянгаар халдварласан эсэхийг тогтоох зорилгоор 16 хүртэлх насны хүүхдэд туберкулины арьсны сорил тавьж, 48-72 цагийн дараа хариуг хэмжиж дараах тохиолдолд **эерэг** гэж үнэлнэ:

- БЦЖ вакцинаар дархлаажуулагдсан эсэхээс үл хамааран 10 мм-ээс дээш хэмжээтэй гүвдрүү;
- ХДХВ-ийн халдвартай, эсвэл хүнд тураалтай буюу хоол тэжээлийн дутагдалтай хүүхдэд 5 мм-ээс дээш хэмжээтэй гүвдрүү;

Туберкулины сорилын хариу хуурамч эерэг, сөрөг гарах тохиолдол

- Хуурамч эерэг: сорилын хариу буруу унших, сүрьеэгийн бус микобактерийн халдвар;
- Хуурамч сөрөг: ХДХВ-ийн халдвартай, туберкулины хадгалалтын горим алдагдсан, вирус, нянгийн гаралтай халдвар, вирусын вакцин хийлгэснээс хойш 6 сарын дотор, хоол тэжээлийн дутагдал, тураал, дархлал дарангуйлах эмчилгээ, уургийн дутал, архаг болон хурц тархмал сүрьеэтэй.


2.7 Дурангийн шинжилгээ (бронхоскопи)

Онош тодруулах зорилгоор хийж болно


Хүснэгт 3 Сүрьеэгийн оношилгоо

д/д	Шинжилгээний арга /2.1 шинжилгээний заалтаас харах/	Өрх, сум, тосгоны ЭМТ, сум дундын эмнэлэг	Аймаг, дүүргийн НЭ, ЭМН	Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн эмнэлэг, амаржих газрууд	ХӨСҮТ
1	Түрхцийн шинжилгээ /2.1/	✓	✓	✓	✓
2	Өсгөвөрлөх шинжилгээ /2.2/		✓		✓
3	Молекул биологийн шинжилгээ /2.4/		✓		✓
4	Эмэнд мэдрэг чанар тодорхойлох шинжилгээ /2.4/				✓
5	Эд эсийн шинжилгээ /2.3/		✓	✓	✓
6	Рентген шинжилгээ /2.5/	✓	✓	✓	✓
7	Туберкулины сорил /2.6/	✓	✓	✓	✓
8	Дурангийн шинжилгээ /2.7/		✓	✓	✓


Бүдүүвч 1. Хүүхдийн сүрьеэг оношлох



Бүдүүвч 2. Насанд хүрэгчдэд уушгины сүрьеэг оношлох




Бүдүүвч 3. Насанд хүрэгчдэд уушгины бус эрхтэний сүрьеэг оношлох



* шингэн тэжээлт орчин
 ** хатуу тэжээлт орчин
 *** молекул биологи

Бүдүүвч 4

15-34 насны хүмүүсийн дунд түрхэц эерэг шинэ тохиолдлыг оношлох



3. Сүрьеэгийн ангилал

Өвчний олон улсын ангиллын шинэчлэн найруулсан 10 дугаар ангиллыг ашиглана.
Бүлэг I - (A15-A19);



- A15 Бактер судлал ба эд судлалаар батлагдсан амьсгалын эрхтэний сүрьеэ
- A15.0 Бичил шинжүүрээр эерэг, цэрний өсгөөртэй буюу өсгөөргүй уушгины сүрьеэ
- A15.1 Зөвхөн өсгөврөөр баталсан уушгины сүрьеэ
- A15.2 Эд судлалаар баталсан уушгины сүрьеэ
- A15.3 Тодорхойгүй аргаар баталсан уушгины сүрьеэ
- A15.4 Бактер судлал ба эд судлалаар баталсан цээжний хөндийн булчирхайн сүрьеэ
- A.15.5 Бактер судлал ба эд судлалаар баталсан төвөнх, мөгөөрсөн хоолой, амьсгуурсны сүрьеэ
- A.15.6 Бактер судлал ба эд судлалаар баталсан хавсын сүрьеэ
- A15.7 Бактер судлал ба эд судлалаар баталсан амьсгалын замын анхдагч сүрьеэ
- A15.8 Бактер судлал ба эд судлалаар баталсан амьсгалын замын бусад сүрьеэ
- A15.9 Бактер судлал ба эд судлалаар баталсан амьсгалын замын тодорхойгүй сүрьеэ

- A16 Бактер судлал ба эд судлалаар батлаагүй амьсгалын замын сүрьеэ
- A16.0 Бактер судлал ба эд судлалын шинжилгээ сөрөг уушгины сүрьеэ
- A16.1 Бактер судлал ба эд судлалын шинжилгээ хийгээгүй уушгины сүрьеэ
- A16.2 Бактер судлал ба эд судлалын шинжилгээгээр баталсан эсэх нь тодорхойгүй уушгины сүрьеэ
- A16.3 Бактер судлал ба эд судлалын шинжилгээгээр баталсан эсэх нь тодорхойгүй цээжний булчирхайн сүрьеэ
- A16.4 Бактер судлал ба эд судлалын шинжилгээгээр баталсан эсэх нь тодорхойгүй төвөнх, мөгөөрсөн хоолой, амьсгуурсны сүрьеэ
- A16.5 Бактер судлал ба эд судлалын шинжилгээгээр баталсан эсэх нь тодорхойгүй сүрьеэгийн плеврит
- A16.7 Бактер судлал ба эд судлалын шинжилгээгээр баталсан эсэх нь тодорхойгүй амьсгалын эрхтэний анхдагч сүрьеэ
- A16.8 Бактер судлал ба эд судлалын шинжилгээгээр баталсан эсэх нь тодорхойгүй амьсгалын бусад эрхтэний сүрьеэ
- A16.9 Бактер судлал ба эд судлалын шинжилгээгээр баталсан эсэх нь тодорхойгүй амьсгалын замын тодорхойгүй сүрьеэ

- A17 Мэдрэлийн сүрьеэ
- A17.0 Сүрьеэгийн мэнэн (G01)
- A17.1 Тархины зөөлөн бүрхүүлийн туберкулом (G07)
- A17.8 Мэдрэлийн бусад сүрьеэ

A17.9 Мэдрэлийн тодорхойгүй сүрьеэ (G99.8)

A18 Бусад эрхтэний сүрьеэ

A18.0 Яс ба үений сүрьеэ

A18.1 Шээс, бэлэг эрхтэний сүрьеэ

A18.2 Сүрьеэгийн гаралтай хязгаарын лимфаденопати

A18.3 Гэдэс, хэвлийн гялтан, чацархайн тунгалгийн булчирхайн сүрьеэ

A18.4 Арьс ба арьсан доорх эслэгийн сүрьеэ

A18.5 Нүдний сүрьеэ

A18.6 Чихний сүрьеэ (H67.0)

A18.7 Бөөрний дээд булчирхайн сүрьеэ (E35.1)

A18.8 Бусад тодорхой эрхтэний сүрьеэ

A19 Түгмэл сүрьеэ

A19.0 Тодорхой байршилт цочмог түгмэл сүрьеэ

A19.1 Олон байршилт цочмог түгмэл сүрьеэ

A19.2 Цочмог түгмэл сүрьеэ, тодорхойгүй

A 19.8 Бусад түгмэл сүрьеэ

A19.9 Түгмэл сүрьеэ, тодорхойгүй



Эрхтэн тогтолцооны эмгэг өөрчлөлтөөр

Уушгины сүрьеэ: Сүрьеэгийн нян уушгины эдийг (паренхими) гэмтээсэн тохиолдол
Тархмал хэлбэрийн сүрьеэ энэ ангилалд орно.


Уушгины бус эрхтэний сүрьеэ: Уушгинаас бусад эрхтэнийг хамарсан сүрьеэгийн тохиолдол. Уушгины эдэд өөрчлөлтгүй гялтан хальсны сүрьеэ, цээжний хөндийн тунгалгийн булчирхайн сүрьеэ энэ ангилалд хамрагдана.

Уушгины бус эрхтэний сүрьеэг эрхтэн тогтолцоог гэмтээсэн байдлаар нь хүнд болон хөнгөн хэлбэр гэж ангилна.

Хүснэгт 4. Уушгины бус эрхтэний сүрьеэгийн ангилал

Хүнд хэлбэрийн сүрьеэ	Хөнгөн хэлбэрийн сүрьеэ
• Менингит; • Үнхэлцэг хальсны; • Хоёр талын уушгины гялтан хальсны; • Нурууны; • Гэдэсний; • Шээс бэлэг эрхтэний.	• Захын тунгалгийн булчирхайн; • Нэг талын уушгины гялтан хальсны; • Нуруунаас бусад яс, үений; • Бөөрний дээд булчирхайн; • Арьсны; • Нүдний.


Уушгины болон уушгины бус эрхтэний сүрьеэгийн хавсарсан тохиолдлыг уушгины сүрьеэгийн ангилалд хамруулна.



1. Өмнөх эмчилгээний түүхээр
 - Шинэ
 - Өмнө нь эмчлэгдэж байсан:
 - Дахилт
 - Эмчилгээ тасалсны дараах
 - Үр дүнгүй эмчлэгдсэний дараах
 - Бусад
2. Сүрьеэ, ХДХВ/ДОХ-ын хавсарсан халдварын байдлаар
 - ХДХВ/ДОХ-ын халдвартай сүрьеэтэй өвчтөн
 - ХДХВ/ДОХ-ын халдваргүй сүрьеэтэй өвчтөн
 - ХДХВ/ДОХ-ын халдвартай эсэх нь тодорхойгүй сүрьеэтэй өвчтөн

4. Сүрьеэгийн эмчилгээ

Бүдүүвч 5.



Насанд хүрэгчдийн сүрьеэгийн эмчилгээний бүлэг ба горим

Сүрьеэгийн эмчилгээ нь эрчимт шат болон үргэлжлэх шатаас бүрдэнэ. Эрчимт шат нь 2-3 сар, үргэлжлэх шат нь 4-5 сар үргэлжилнэ.

Эмчилгээний I дүгээр бүлэг

- Шинэ, нян судлалын шинжилгээгээр батлагдсан уушгины сүрьеэгийн тохиолдол
- Шинэ, эмнэлзүйгээр оношлогдсон, уушгины талбайг их хэмжээгээр хамарсан өөрчлөлттэй
- Шинэ, уушгины бус эрхтэний сүрьеэгийн хүнд хэлбэр

Эмчилгээний горим: 2HRZE (S) / 4HR

Эмчилгээний эрчимт шатыг сунгах:

Шинэ, нян судлалаар батлагдсан уушгины сүрьеэгийн тохиолдол нь эмчилгээ хяналтын 2 дахь сарын түрхцийн шинжилгээнд эерэг бол эрчимт шатны эмчилгээг 1 сараар сунгана.

Эмчилгээний II дугаар бүлэг

- Өмнө нь эмчлэгдэж байсан: Дахилт; үр дүнгүй эмчлэгдсэний дараах; эмчилгээ тасалсны дараах; бусад

Эмчилгээний горим: 2HREZS / 1 HREZ / 5 HRE

Эмчилгээний III дугаар бүлэг

- Шинэ, эмнэлзүйгээр оношлогдсон уушгины сүрьеэгийн тохиолдол
- Шинэ, уушгины бус эрхтэний сүрьеэгийн хөнгөн хэлбэр

Эмчилгээний горим: 2HRZE / 4HR

Хүснэгт 5. Хүүхдийн эмчилгээний бүлэг ба горим

Заалт	Эмчилгээний горим	
	Эрчимт шат	Үргэлжлэх шат
- Түрхэц сөрөг уушгины сүрьеэ - Уушгины угийн булчирхайн сүрьеэ - Захын тунгалгийн булчирхайн сүрьеэ	2 HRZ	4 HR
- Уушгины сүрьеэгийн хүнд хэлбэрүүд - Түрхэц эерэг уушгины сүрьеэ - Уушгины бус эрхтний сүрьеэгийн хүнд хэлбэр (сүрьеэгийн менингит болон яс үений сүрьеэ хамаарахгүй)	2 HRZE	4 HR
- Сүрьеэгийн менингит - Яс үений сүрьеэ	2 HRZE	10 HR
- ОЭТС	Хувь хүнд тохирсон горим	

Хүснэгт 6. Насанд хүрэгчдийн сүрьеэгийн эмийн тун

Эмийн нэр	Зөвлөмж болгож буй тун		Эмийн үйлчилгээ
	Тун мг/кг (тунгийн хэлбэлзэл)	Хоногийн дээд тун мг	
Изониазид	5 (4-6)	300	Нян устгах
Рифамицин	10 (8-12)	600	
Пиразинамид	25 (20-30)	-	
Этамбутол	15 (15-20)	-	Нянгийн үржлийг дарангуйлах
Стрептомицин	15 (12-18)		Нян устгах

Хүснэгт 7. Хүүхдийн сүрьеэгийн эмийн тун

Эмийн нэр	Зөвлөмж болгож буй тун	
	Тун мг/кг(тунгийн хэлбэлзэл)	Хоногийн дээд тун (мг)
Изониазид	10 (7-15)	300
Рифамицин	15 (10-20)	600
Пиразинамид	35 (30-40)	-
Этамбутол	20 (15-25)	-

Хүснэгт 8. Сүрьеэгийн эмийн тогтсон тунтай хослол

Эмийн бэлдмэлийн нэр (эмийн товчлол, эмийн хэлбэр)	Биеийн жинд тохирсон эмийн тун (шахмал тоогоор)			
	30-39кг	40-54 кг	55-70 кг	71кг <
1 ба 3 дугаар бүлэг				
2RHZE(150/75/400/275) / 4RH(150/75) (шахмал тоогоор)	2	3	4	5
2 дугаар бүлэг				
3RHZE(150/75/400/275) /5RHE(150/75/275) (шахмал тоогоор)	2	3	4	5
2S (1 г туншил)	0.5 г	0.75г	1г	1г

Шинэ тохиолдол: Хүүхдийн эмийн тунг кг жинд тооцож уулгана.

Хүснэгт 9. Этамбутолгүй горимоор

Биеийн жин	ЭЭШ (2 сар)		ҮЭШ (4 сар)	
	RHZ (60,30,150) (шахмал)	RH (60,60) (шахмал)	RH (60,30) (шахмал)	RH (60,60) (шахмал)
5 -7 кг	1	1	1	1
8-14 кг	2	1	2	1
15-20 кг	3	2	3	2

Хүснэгт 10. Этамбутолтой горимоор

Биеийн жин	ЭЭШ (2 cap)			ҮЭШ (4 cap)	
	RHZ (60,30,150) (шахмал)	RH (60,60) (шахмал)	E (100) (шахмал)	RH (60,30) (шахмал)	RH (60,60) (шахмал)
5 -7 кг	1	1	1	1	1
8-14 кг	2	1	2	2	1
15-20 кг	3	2	3	3	2

Хүснэгт 11. Этамбутолгүй горимоор

Биеийн жин	ЭЭШ (2 cap)			ҮЭШ (4 cap)	
	RH (150,75) (шахмал)	RH (60,60) (шахмал)	Z (400) (шахмал)	RH (150,75) (шахмал)	RH (60,60) (шахмал)
21-30 кг	2	2	2	2	2

Хүснэгт 12. Этамбутолтой горимоор

Биеийн жин	ЭЭШ (2 cap)		ҮЭШ (4 cap)	
	RHZE (150,75,400,275)		RH (60,60)	RH (150,75)
21-30 кг	2шахмал		2шахмал	2шахмал

Давтан тохиолдол

Хүснэгт 13.

Биеийн жин	ЭЭШ (3 cap)			ҮЭШ (5 cap)		
	RHZ(60,30,150) (шахмал)	RH (60,60) (шахмал)	E (100) (шахмал)	RH (60,30) (шахмал)	RH (60,60) (шахмал)	E (100) (шахмал)
5 -7 кг	1	1	1	1	1	1
8-14 кг	2	1	2	2	1	2
15-20 кг	3	2	3	3	2	3

Хүснэгт 14.


Биеийн жин	ЭЭШ (3 cap)		ҮЭШ (5 cap)		
	RHZE (150,75,400,275)	RH (60,60)	RH (150,75)	RH (60,60)	E (400)
21-30 кг	2шахмал	2 шахмал	2 шахмал	2 шахмал	1 шахмал

Тайлбар: 21-30 кг жинтэй хүүхэд эмчилгээний шатандаа RHZE (150,75,400,275) эмнээс 2 шахмал, RH (60,60) эмнээс 2 шахмал, нийтдээ 4 шахмал эм ууна.

Сүрьеэгийн өвөрмөц эмчилгээний горим:

Тархмал, хүнд хэлбэрийн сүрьеэгийн эмчилгээ

Сүрьеэгийн менингит, хурц тархмал сүрьеэ, мэдрэл гэмтсэн нурууны сүрьеэ, уушгины сүрьеэгийн зарим хүнд хэлбэрийн үед эмнэлзүйн байдлаас хамаарч үргэлжлэх шатанд изониазид ба рифампициныг 7 сар уулгана.



Мэс заслын эмчилгээ

Эмийн эмчилгээгээр төгс эмчлэгдэх боломжгүй, уушгины сүрьеэгийн хүндрэл, үнхэлцэг хальс, яс үе, хэвлийн сүрьеэ, буглаа, идээт үрэвслийн үед мэс засал эмчилгээг эмийн эмчилгээтэй хавсарч хийнэ. Мэс заслын эмчилгээг эмийн эмчилгээ эхэлсэнээс хойш 2 сарын дараагаар эхэлнэ. Яаралтай тохиолдолд мэс заслын эмчилгээг хугацаа харгалзахгүй хийнэ.

Хавсарсан эмгэгтэй өвчтөнд сүрьеэгийн эмчилгээг хийх явцад сүрьеэгийн эмч нь мэдрэл, дотор, бөөр, дотоод шүүрэл, эмэгтэйчүүдийн зэрэг мэргэжлийн эмчийн хамтарсан үзлэг зөвлөгөөнийг тогтмол хийнэ.

Сүрьеэтэй жирэмсэн ба хөхүүл эхийн эмчилгээ

Сүрьеэтэй жирэмсэн болон хөхүүл эхэд сүрьеэгийн эмчилгээ эхэлсэн тохиолдолд бүрэн хийнэ. Сүрьеэгийн эмчилгээ хийлгэж байгаа үед хүүхдээ хөхүүлж болно. Эмчилгээнд стрептомицинийг хэрэглэхийг хориглоно.

Сүрьеэгийн эмчилгээ хийлгэж байгаа жирэмсэн, хөхүүл эмэгтэйд Витамин В6 (100мг)-ыг өдөрт 2 шахмалыг эмчилгээний туршид уулгана.

Сүрьеэтэй эмэгтэй рифампицин ууж байх үедээ жирэмслэхээс хамгаалах дааврын бэлдмэл хэрэглэх үед дааврын бэлдмэлийн үйлчилгээг бууруулдаг учраас эстрогений тун 50 мг/кг-аас дээш бэлдмэлийг эсвэл гэр бүл төлөвлөлтийн өөр арга сонгохыг зөвлөнө.

Элэгний үйл ажиллагааны алдагдалтай өвчтөний сүрьеэгийн эмчилгээ

Элэгний хүнд хэлбэрийн эмгэг, элэгний эмгэгийн сэдрэл даамжирсан үед пиазинамидыг хэрэглэхгүй, элэгний үйл ажиллагааг тогтмол хянаж дараах горимуудаас аль нэгийг сонгож хэрэглэнэ: 9HER; 2HERS/ 6HR; 2SHE/10HE

Элэгний архаг үрэвсэлтэй өвчтөнд сүрьеэгийн эмчилгээний явцад цусан дахь АлАТ, АсАТ-ын хэмжээ 3 дахин ихэссэн үед сүрьеэгийн эмийг түр зогсоож хордлого тайлах, элэгний үйл ажиллагааг дэмжих эмчилгээг хийнэ. АлАТ, АсАТ-ын хэмжээ хэвийн болсон үед эмчилгээг үргэлжлүүлнэ.

Элэгний хурц үрэвсэлтэй үед идэвхжлийг намжтал сүрьеэгийн эмийг хойшлуулна.

Бөөрний дутагдалтай өвчтөний сүрьеэгийн эмчилгээ

Бөөрний хурц дутагдалтай өвчтөнд 2HRZE/4HR горимыг хэрэглэнэ. Бөөрний дутагдалтай өвчтөнд Н хэрэглэж байгаа тохиолдолд захын мэдрэлийн эмгэг үүсэхээс сэргийлж Витамин В6 (100мг)-ыг өдөрт 2 шахмалыг эмчилгээний туршид сүрьеэгийн эмчийн хяналтанд уулгана.

Сонсгол болон бөөрний эрхтэний хордлогоос сэргийлж, бөөрний дутагдалтай өвчтөний эмчилгээнд стрептомицин хэрэглэхгүй. Хэрэв хэрэглэх шаардлагатай тохиолдолд стрептомициныг 15 мг/кг-аар долоо хоногт 3 удаа тарьж хэрэглэнэ.

Чихрийн шижинтэй өвчтөний сүрьеэгийн эмчилгээ

Пиразинамидыг хэрэглэхдээ цусан дахь сахарын хэмжээг хоногт 1-2 удаа хянана. Инсулин эмчилгээг дотоод шүүрлийн эмчийн заалтаар тариагаар хийнэ.

Бусад эмчилгээ

Шаардлагатай тохиолдолд хордлого тайлах, зүрх судасны үйл ажиллагааг дэмжих, амин дэм, гаж нөлөө, хүндрэлийн эсрэг шинж тэмдгийн эмчилгээ хийнэ.

Сүрьеэгийн хяналттай эмчилгээ

Сүрьеэгийн эмч оношлогдож бүртгэгдсэн өвчтөний биеийн байдал, эмнэлзүйн илрэл, нийгмийн байдал, халдвар хамгааллын эрсдэл зэргийг харгалзан шууд хяналттай эмчилгээг хаана хийхийг шийдвэрлэнэ.

ХӨСҮТ-ийн сүрьеэгийн клиникт:

- Өвчтөний биеийн байдал хүнд цэрний түрхцийн шинжилгээнд хүчилд тэсвэртэй нян (ХТН) эерэг эсвэл сөрөг тохиолдол
- Өвчтөний биеийн байдал хүндэвтэр цэрний түрхцийн шинжилгээнд ХТН эерэг тохиолдол
- Сүрьеэгийн менингит
- Сүрьеэгийн мэс заслын заалттай тохиолдол

Аймгийн нэгдсэн эмнэлэг, Энэрэл эмнэлгийн сүрьеэгийн тасагт:

- Өвчтөний биеийн байдал хүнд, хүндэвтэр цэрний түрхцийн шинжилгээгээр ХТН эерэг эсвэл сөрөг тохиолдол
- Өвчтөний биеийн байдал дунд; цэрний түрхцийн шинжилгээнд ХТН эерэг тохиолдол

Аймаг, дүүргийн сүрьеэгийн кабинет:

- Өвчтөний биеийн байдал дунд, хөнгөн цэрний түрхцийн шинжилгээгээр ХТН эерэг эсвэл сөрөг тохиолдол

Сүрьеэгийн өдрийн эмчилгээний цэгт:

- Өвчтөний биеийн байдал хөнгөн цэрний түрхцийн шинжилгээгээр ХТН эерэг эсвэл сөрөг тохиолдол

Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэгт

- Өвчтөний биеийн байдал хөнгөн цэрний түрхцийн шинжилгээгээр ХТН сөрөг тохиолдол

Эрүүл мэндийн сайн дурын идэвхтэнүүдээр

- Өвчтөний биеийн байдал дунд, хөнгөн түрхцийн шинжилгээгээр ХТН сөрөг тохиолдол
- Эрхтэн тогтолцооны өөрчлөлтийн улмаас хэвтэрт байдаг, түрхцийн шинжилгээгээр ХТН сөрөг тохиолдол-

Хүнд өвчтөнг эмнэлэг хооронд шилжүүлэх

- Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдэд эмчлэгдэж байгаа сүрьеэгийн сэжигтэй тохиолдлыг сүрьеэгийн онош тодруулах шинжилгээг бүрэн хийсний дараа сүрьеэгийн мэргэжлийн эмчийг дуудаж зөвлөгөө авна. Тухайн тохиолдолд нян судлал, эд эсийн шинжилгээний аль нэгээр онош батлагдсан тохиолдолд шилжүүлэх асуудлыг шийдвэрлэнэ.
- Эрүүл мэндийн байгууллагуудад эмчлэгдэж байхдаа оношлогдсон сүрьеэтэй өвчтөний биеийн байдал хүнд, тээвэрлэх боломжгүй үед халдвар ялгаруулж байгаа эсэхээс үл хамааран биеийн байдал тогтворжтол тухайн эмнэлэгт сүрьеэгийн тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

Эмчилгээний хяналт

Сүрьеэгийн эмчилгээний хяналтыг доорх үндсэн чиглэлийн дагуу хийнэ. Уушгины сүрьеэтэй шинэ тохиолдолд эмчилгээний 2(3), 5, 6 дахь сард; давтан тохиолдолд 3, 5, 8 дахь сард цэрний 2 сорьцоор түрхцийн шинжилгээ хийнэ.

Эмчилгээний явцад:

- Бодит үзлэг хийхдээ өвчтөний биеийн жинг эмчилгээний явцад сар бүр үзэж тэмдэглэнэ.
- Рентген шинжилгээг эмчилгээний эхэнд, эрчимт шатны төгсгөл болон эмчилгээний төгсгөлд хийнэ. Өвчтөний биеийн байдал сайжрахгүй, мэс засал хийгдэх шаардлагатай тохиолдолд хугацаа харгалзахгүй.
- Цусны дэлгэрэнгүй, биохими, шээсний ерөнхий шинжилгээнд эмчилгээний өмнө хамруулах ба шаардлагатай тохиолдолд хугацаа харгалзахгүй давтана.
- ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээнд үйлчилгээ үзүүлэгчийн санаачилгаар эмчилгээний эхэнд илгээнэ.

Эмийн гаж нөлөө

25

Хүснэгт 15. Сүрьеэгийн эмийн гаж нөлөөг хянах

Гаж нөлөө	Гаж нөлөө үүсгэж болзошгүй эм	Авах арга хэмжээ
Их		Гаж нөлөө үүсгэж буй эмийг зогсоох, эмнэлзүйч эмчид илгээнэ.
Арьсаар тууралт гарах	S, H, R, Z	Антигистамины бэлдмэл хэрэглэж сүрьеэгийн эмчилгээг хяналтад үргэлжлүүлнэ. Хэрэв тууралт нэмэгдвэл сүрьеэгийн эмүүдийг зогсооно. Харшлын урвал зогссоны дараа харшил үүсгэж болзошгүй сүрьеэгийн эмүүдийг (H / R) нэг нэгээр нь бага тунгаар уулгаж, тунг 3 хоногийн дотор ихэсгэнэ. Харшил үүсгэж буй эмийг тогтоовол тэр эмийг эмчилгээнээс хасч, өөр эм орлуулж хэрэглэнэ.
Дүлийрэх	S	Стрептомицин эмчилгээг зогсооно.
Толгой эргэх	S	
Арьс салт шарлах, элэгний үрэвсэл	H, R, Z	Сүрьеэгийн эмийг зогсооно.
Ухаан балартах	Сүрьеэгийн ихэнх эмүүд	
Хараа муудах	E	Этамбутолыг зогсооно
Шок, гүвдрүүн тууралт, бөөрний хурц дутагдал	R	Рифампицин эмчилгээг зогсооно.
Шээсний гарц багасалт	S	Стрептомициныг зогсооно.
Бага		Сүрьеэгийн эмийг үргэлжлүүлэн хэрэглэх, эмийн тунг хянана.
Хоолны дуршил буурах, дотор муухайрах, хэвлийгээр өвдөх	Z, R, H	Эмийг хоол идэх үед, эсвэл орой унтахын өмнө; бага хэмжээний устай хамт залгиж уухыг зөвлөнө. Шинж тэмдэг нэмэгдэх, байнга бөөлжих, цус алдах зовиур илэрвэл холбогдох мэргэжлийн эмчид яаралтай илгээнэ.
Үеэр өвдөх	Z	Стройдын бус үрэвслийн эсрэг эм (аспирин, парацетамол гэх мэт) хэрэглэнэ
Гар, хөл халуу оргих, чимчигнэх, бадайрах	H	Витамин B6 (100мг)-ыг өдөрт 1 ширхэгээр шинж тэмдэг арилтал уулгана.
Нойрмоглох	H	Эмийг унтахын өмнө уулгана.
Шээс улаан/улбар шар өнгөтэй болох	R	Эмчилгээг эхлэхийн өмнө өвчтөнд эмийн улмаас шээсний өнгө өөрчлөгдөнө гэдгийг тайлбарлана.

Эмчилгээний үр дүнг тооцох:

Эдгэрсэн

Эмчилгээ дуусгасан

Үр дүнгүй

Хяналт алдагдсан

Нас барсан

Шилжсэн

Эмчилгээний үр дүн дүгнэгдээгүй



Эмчилгээний эхэнд болон 2 дахь эсвэл 3 дахь сарын сорьцонд рифампицин эсвэл олон эмэнд тэсвэртэй нь тогтоогдсон тохиолдлыг дээрх ангиллаас хас, ч эмэнд тэсвэртэй сүрьеэгийн тохиолдолд тооцно.

5. Урьдчилан сэргийлэлт

Сүрьеэгээс урьдчилан сэргийлэх аргыг:

- Сүрьеэгийн өвөрмөц урьдчилан сэргийлэлт (Сүрьеэгийн эсрэг дархлаажуулалт)
- Сүрьеэгийн халдвар авахаас урьдчилан сэргийлэх
- Сүрьеэгээр өвчлөхөөс урьдчилан сэргийлэх гэж 3 ангилна.

Өвөрмөц урьдчилан сэргийлэлт

Нярайг төрсний дараа 24 цагийн дотор эсрэг заалт байгаа эсэхийг тодруулсны дараа бэлтгэгдсэн сувилагч БЦЖ вакцинаар дархлаажуулан тарилгын болон эрүүл мэндийн дэвтэрт тэмдэглэнэ, вакцин хийгдээгүй бол шалтгааныг заана. Вакцины дараах хүндрэл гарсан тохиолдолд холбогдох зааврын дагуу мэдээлж арга хэмжээ авна.

Нөхөн дархлаажуулалт

- Нярайд хийсэн БЦЖ вакцины анхны тунгийн үр дүнг 1, 3, 12 сартайд нь вакцины урвалын байдал (гүвдрүү, шархлаа, сорви), хэмжээгээр нь үнэлэн эрүүл мэндийн дэвтэрт тэмдэглэж, хэрэв сорви үүсээгүй бол туберкулины сорил тавьж сөрөг тохиолдолд нөхөн дархлаажуулна.
- Төрөхөд хориглох заалтаар БЦЖ вакцин хийлгээгүй хүүхдэд хориглох заалт арилсны дараа туберкулины сорил тавьж нөхөн дархлаажуулалт хийнэ.
- Бусад шалтгаанаар БЦЖ вакцин хийлгээгүй 1 хүртэлх насны хүүхдэд туберкулины сорил тавьж, сорилын хариу сөрөг бол нөхөн дархлаажуулалт хийнэ.

Сүрьеэгийн халдвар авахаас урьдчилан сэргийлэх

Урьдчилан сэргийлэх хамгийн үр дүнтэй, ач холбогдолтой арга нь халдварын эх уурхайг аль болох эрт халдваргүй болгох юм.

Хүн амын дунд сүрьеэ өвчний тухай үнэн зөв ойлголтыг хүргэх ухуулга, сурталчилгааны ажлыг мэдээлэл сурталчилгааны бүх хэрэгслийг ашиглан тогтмол зохион байгуулна.

Сүрьеэгээр өвчлөхөөс урьдчилан сэргийлэх

Сүрьеэгийн халдвар авсан тохиолдолд өвчлөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор химийн аргаар урьдчилан сэргийлэх эмчилгээг хийдэг.

Хавьтлын урьдчилан сэргийлэх эмчилгээ

- Эмэнд мэдрэг сүрьеэтэй өвчтөний хавьтал 5 хүртэлх насны хүүхдэд сорилын урвал 10 мм-ээс дээш хэмжээтэй гарч эмнэлзүй, нян судлал, бусад шинжилгээгээр сүрьеэ үгүйсгэгдсэн тохиолдолд урьдчилан сэргийлэх эмчилгээг изониазидаар, өдөрт 10 мг/кг-аар (хоногийн дээд тун 300мг) 6 сар хийнэ
- Сорилын урвал 10 мм-ээс дээш хэмжээтэй гарсан 5-аас дээш насны хүүхдэд холбогдох бусад шинжилгээ хийж сүрьеэ үгүйсгэгдсэн тохиолдолд 2 жил эмчийн хяналтанд байлгана
- Сүрьеэгийн хавьталгүй туберкулины сорил 15 мм-ээс дээш гарсан 0-16 насны хүүхдийг сүрьеэ өвчнийг оношлох шинжилгээнд хамруулж, сүрьеэ үгүйсгэгдсэн тохиолдолд 5 хүртэлх насанд урьдчилан сэргийлэх эмчилгээг изониазидаар хийнэ
- Эмэнд тэсвэртэй сүрьеэтэй өвчтөний хавьтал 5 хүртэлх насны хүүхдэд урьдчилан сэргийлэх эмчилгээ хийхгүй

6. Эрүүл мэндийн байгууллагын халдваргүйтгэл, ариутгал


Дараах халдваргүйтгэх уусмалын аль нэгээс өвчтөний цэртэй ижил хэмжээтэй хийж цэрийг халдваргүйтгэнэ.

- 5%-ийн фенолын уусмалд 12-24 цаг
- 1-2%-ийн натрийн буюу калийн гипохлоридын уусмал уусмалд 18-24 цаг
- 3%-ийн хлорамины уусмалд 1 цаг
- Автоклавыг ариутгал, халдваргүйтгэлийн зориулалтаар хэрэглэнэ. Бохирлогдсон цэрний савыг 121°C-ийн хэмд 1 цаг, харин угааж цэвэрлэсэн савыг 30 минутын турш халдваргүйтгэнэ
- Ариутгах боломжгүй 1 удаагийн хэрэглээний материалуудыг шатааж устгана
- Өвчтөний эдлэл (хөнжил, гудас, дэр, бүтээлэг гэх мэт) хэрэглэлийг дезкамерт халдваргүйжүүлэх, эсвэл нарны шууд туяанд 8 цагаас доошгүй хугацаагаар тавина

7. Эмэнд мэдрэг сүрьеэтэй өвчтөнг бүртгэх, мэдээлэх

- 7.1 Аймаг, дүүргийн сүрьеэгийн амбулаторийн эмч нян судлалаар болон эмнэлзүйгээр батлагдсан эмэнд мэдрэг сүрьеэгийн шинэ, дахилт, өмнө эмчлэгдсэн тохиолдлыг "Сүрьеэтэй өвчтний бүртгэл" (CY-03)-д бүртгэн өвчтөн бүрт "Сүрьеэтэй өвчтний эмчилгээ хяналтын карт" (CY-01) нээнэ.
- 7.2 Өвчтөн ХӨСҮТ-ийн сүрьеэгийн клиникт эмэнд мэдрэг сүрьеэгээр хэвтэн эмчлүүлсэн бол эмнэлгээс гарахад нь "Эмнэлэгт хэвтэж эмчлүүлэгчдийн карт" (CY-13)-ын хамт эмчилгээг үргэлжлүүлэх байгууллагад шилжүүлнэ.

- 7.3 Өвчтөн эмчилгээний хугацаанд шилжсэн тохиолдолд “Өвчтөнг шилжүүлсэн мэдээ”(СҮ-09)-г 3 хувь бичиж өвчтөн, эмчилгээг үргэлжлүүлэх эрүүл мэндийн байгууллага, Сүрьеэгийн тандалт судалгааны албанд тус тус өгнө.
- 7.4 Сүрьеэгийн сарын болон улирлын тайланг зохих хугацаанд нь ХӨСҮТ-ийн СТСА-нд илгээнэ.
- “Шинэ илэрсэн болон давтан бүртгэгдсэн өвчтөний сарын тайлан” (СҮ-07)
 - “Шинээр илэрсэн сүрьеэ өвчнийг мэдээлэх хуудас” (АМ-4)
 - Сүрьеэгийн I эгнээний эмийн тайлан.
 - “Уушгины нян судлалаар батлагдсан өвчтөний эмчилгээний 2, 3 дахь сард түрхэц сөрөгт шилжсэн байдал” (СҮ-14)
 - “12-15 сарын өмнө бүртгэгдсэн сүрьеэтэй өвчтөний эмчилгээний үр дүнгийн тайлан” -г эмчилгээний хяналтын картын хамт (СҮ-08)



ЭМЭНД ТЭСВЭРТЭЙ СҮРЬЕЭГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗААВАР

1. Тодорхойлолт, нэр томъёо

Сүрьеэгийн эсрэг эмэнд тэсвэртэй нянгаар үүсгэгдсэн нь лабораториор батлагдсан тохиолдлыг эмэнд тэсвэртэй сүрьеэ (ЭТС) гэнэ.

ЭТС-н сэжигтэй тохиолдол:

- Сүрьеэгийн 1 ба 2 дугаар бүлгийн эмчилгээний 2(3) дахь сар, 5 дахь сард түрхэц эерэг
- Сүрьеэгийн 1 ба 2 дугаар бүлгийн эмчилгээ тасалсны дараах түрхэц эерэг
- Дахилт (Сүрьеэгийн 1 ба 2 дугаар бүлгийн эмчилгээний дараа)
- Бусад: Өмнөх эмчилгээний бүлэг, горим тодорхойгүй эсвэл түрхэц сөрөг; эмчилгээний эхэнд сөрөг байсан өвчтөн эмчилгээний явцад эерэг болсон; ЭТС-тэй өвчтөний гэр бүлийн гишүүд, ойрын хавьтлаас сүрьеэ оношлогдох; ХДХВ/ДОХ, сүрьеэ хавсарсан халдвартай өвчтөн

Маш олон эмэнд тэсвэртэй сүрьеэгийн (МОЭТС) сэжигтэй тохиолдол:

- Сүрьеэгийн 2 дугаар эгнээний эмийг 2 сар ба түүнээс дээш хугацаанд хэрэглэсэн
- ОЭТС-ийн эмчилгээний 3 дахь сард өсгөвөр эерэг
- ОЭТС-ийн эрчимт шатны эмчилгээний төгсгөлд сөрөгт шилжээгүй
- ОЭТС-ийн үргэлжлэх шатны эмчилгээний үед сөрөгт шилжсэний дараа нян судлалын шинжилгээгээр дахин эерэг
- Эмчилгээний явцад фторхинолоны бүлэг эсвэл 2 дугаар эгнээний тарьж хэрэглэдэг эмийн аль нэгэнд тэсвэртэй болох нь тогтоогдсон ОЭТС
- МОЭТС-н ойрын хавьтал

Нэг эмэнд тэсвэртэй сүрьеэгийн тохиолдол:

Сүрьеэгийн эсрэг аль нэг эмэнд тэсвэртэй

Цөөн эмэнд тэсвэртэй сүрьеэгийн тохиолдол:

Изониазид ба рифампицины хослолоос бусад нэгээс дээш эмэнд тэсвэртэй

Олон эмэнд тэсвэртэй сүрьеэгийн тохиолдол:

Изониазид ба рифампицинд хоёуланд тэсвэртэй, эсвэл изониазид ба рифампицин оролцсон горимд тэсвэртэй

Маш олон эмэнд тэсвэртэй сүрьеэгийн тохиолдол:

Олон эмэнд тэсвэртэйн дээр фторхинолоны бүлгийн эмүүдийн аль нэг, мөн 2 дугаар эгнээний тарьж хэрэглэдэг эмүүдийн аль нэгэнд нь тэсвэртэй тохиолдол

Рифампицинд тэсвэртэй сүрьеэ

Эмэнд тэсвэртэй сүрьеэгийн бүх хэлбэрээс рифампицин оролцсон тэсвэржилт хамаарна (нэг-зөвхөн рифампицинд тэсвэртэй, цөөн-рифампицин оролцсон тэсвэржилт, олон эмэнд тэсвэртэй сүрьеэ, маш олон эмэнд тэсвэртэй сүрьеэ)

Шинэ тохиолдол

Сүрьеэгийн эмчилгээ хийлгэж байгаагүй эсвэл сүрьеэгийн эмийг 1 сар хүртэлх хугацаанд хэрэглэж байсан тохиолдол

Өмнө нь эмчлэгдэж байсан тохиолдол

Өмнө нь 1 сараас дээш хугацаагаар сүрьеэгийн эм ууж байсан тохиолдол.

Дахисан тохиолдол

Өмнөх эмчилгээний үр дүн эдгэрсэн эсвэл эмчилгээ дуусгасан гэж дүгнэгдсэн боловч дахин сүрьеэгээр өвчилсөн тохиолдол

Эмчилгээ үр дүнгүй болсны дараах тохиолдол

Өмнөх эмчилгээ нь үр дүнгүй гэж дүгнэгдсэн тохиолдол

Эмчилгээ тасалсны дараах тохиолдол

Өмнөх эмчилгээний үр дүн эмчилгээ тасалсан гэж дүгнэгдсэн тохиолдол

Бусад тохиолдол

Өмнөх эмчилгээний үр дүн тодорхойгүй тохиолдол

Өмнөх эмчилгээний түүх тодорхойгүй тохиолдол

Дээрх ангилалд хамрагдахгүй тохиолдол

2. ЭТС-ийн оношилгоо


MTB* сүрьеэгийн нян

H** изониазид

R*** рифампицин

ЭМЧ**** эмэнд мэдрэг чанар тодорхойлох


Бүдүүвч 6.



Бүдүүвч 7. Маш олон эмэнд тэсвэртэй сүрьеэг оношлох



Хайн тест* олон эмэнд тэсвэртэй сүрьеэг оношлох хурдавчилсан оношилгооны арга



3. Ангилал

Эмэнд тэсвэржилт үүсэх шалтгаанаар нь:

Анхдагч тэсвэржилт:

Сүрьеэгийн эмчилгээ огт хийлгэж байгаагүй буюу нэг сараас доош хугацаагаар хийлгэсэн өвчтөн эмэнд тэсвэртэй нь тогтоогдвол

Хоёрдогч тэсвэржилт:

Сүрьеэгийн эсрэг эмчилгээг 1 сар ба түүнээс дээш хугацаанд хийлгэсэн өвчтөн эмэнд тэсвэртэй нь тогтоогдвол

Эмэнд тэсвэржилтийн хэлбэрээр:

Нэг эмэнд; цөөн эмэнд; олон эмэнд; маш олон эмэнд; рифампицинд тэсвэртэй

Өмнөх эмчилгээний түүхээр нь:

Шинэ

Өмнө нь эмчлэгдэж байсан. Эдгээр тохиолдлыг сүүлийн эмчилгээний үр дүнгээр дараах байдлаар ангилна:

- Дахилт
- Эмчилгээ тасалсаны дараах
- Үр дүнгүй эмчлэгдсэний дараах

Бусад

Өмнөх эмчилгээний түүх тодорхойгүй+++

4. Эмэнд тэсвэртэй сүрьеэгийн (ЭТС) эмчилгээ

ЭТС-ийн эрчимт эмчилгээний шат (ЭЭШ) 8 сар, үргэлжлэх эмчилгээний шат (ҮЭШ) 12-16 сар, нийт үргэлжлэх хугацаа 18-24 сар байх ба 4-7 төрлийн эм бэлдмэлийг хослуулан хэрэглэнэ.

Хүснэгт 16. Насанд хүрэгсдийн ЭТС-ийн эмийн тун

Эмийн нэр (эмийн товчлол, эмийн хэлбэр)	Биеийн жинд тохирсон эмийн тун			
	<33 кг	33-50кг	51-70кг	>71 кг (дээд тун)
I бүлэг: 1 дүгээр эгнээний ууж хэрэглэх эм				
Изониазид (H) (100, 300 мг шахмал)	4-6 мг/кг	200-300 мг	300мг	300 мг
Рифампицин (R) (150, 300 мг шахмал)	10-20 мг/кг	450-600 мг	600 мг	600 мг
Этамбутол (E) (100, 400 мг шахмал)	25 мг/кг	800-1200 мг	1200-1600 мг	1600-2000 мг

Пиразинамид (Z) (400 мг шахмал)	30-40 мг/кг	1000-1600мг	1600-2000 мг	2000-2400 мг
II бүлэг: Тарилгын бэлдмэл				
Стрептомицин (S) (1 г флакон)	15-20 мг/кг	500-750 мг	1000 мг	1000 мг
Канамицин (Km) (1 г флакон)	15-20 мг/кг	500-750 мг	1000 мг	1000 мг
Амикацин (Am) (1 г флакон)	15-20 мг/кг/хоногт	500-750 мг	1000 мг	1000 мг
Капреомицин (Cm) (1 г флакон)	15-20 мг/кг	500-750 мг	1000 мг	1000 мг
III бүлэг: Фторхинолоны бүлгийн эм				
Ципрофлоксацин (Cx) (250, 500, 750 мг шахмал)	20-30 мг/кг	1500 мг	1500 мг	1500 мг
Офлоксацин (Ofx) (200, 300, 400 мг шахмал)	800 мг	800 мг	800 мг	800-1000 мг
Левифлоксацин (Lfx) (250, 500 мг шахмал)	750 мг	750 мг	750 мг	750-1000 мг
Моксифлоксацин (Mfx) (400 мг шахмал)	400 мг	400 мг	400 мг	400 мг
Гатифлоксацин (Gx) (400 мг шахмал)	400 мг	400 мг	400 мг	400 мг
IV бүлэг: 2 дугаар эгнээний ууж хэрэглэх бактериостатик үйлчилгээтэй эм				
Этионамид (Eto) (250 мг шахмал)	15-20 мг/кг	500 мг	750 мг	750-1000 мг
Протионамид (Pto) (250 мг шахмал)	15-20 мг/кг	500 мг	750 мг	750-1000 мг
Циклосерин* (Cs) (250 мг капсул)	15-20 мг/кг	500 мг	750 мг	750-1000 мг
Теризидон (Trd) (300 мг шахмал)	15-20 мг/кг	600 мг	600 мг	900 мг
Парааминосалицилийн хүчил (PAS) (4 гнунтаг, PASER)	150 мг/кг/хоногт	8 г	8 г	8-12г
Тиацетазон(Thz)	Насанд хүрэгсдэд 150 мг			
V бүлэг: 3 дугаар эгнээний, өргөн хүрээний үйлчилгээтэй эм				
Клофазимин (Cfz) (100 мг, капсул)	Хоногийн тун 200 мг			
Линезолид (Lzd) (600 мг, шахмал)	12-оос дээш насанд 10 мг/кг тунгаар 8 цагийн зайтай ууна			

Амоксициллин/ клавуланат (Amx/Clv) (875 мг/ 125 мг, шахмал)	30 мг/кг тунгаар 12 цагийн зайтай ууна
Имипенем/силастатин (Ipm/ Cln) + Меропенем (Mpm) (500 мг/500 мг, флакон)	Булчинд эсвэл судсанд 6-8 цагийн зайтай тарьж хэрэглэх ба эмчийн заавраар тунг нэмж хасаж болно
Бедакулин (bedaquiline)	400мг тунгаар өдөрт нэг удаа ууна
Кларитромицин (Clr) (500 мг, шахмал)	500 мг тунгаар 6-8 цагаар ууна
Изониазид, өндөр тунгаар (H)	16-20 мг/кг тунгаар өдөрт 1 удаа ууна

* Циклосерин 250 мг тунгаар ууж байгаа бол витамин B6 (100мг) ½ ширхэг, 500 мг бол 1 ширхэг, 750 мг бол 1 ½ ширхэг тус тус эмчилгээний турш уулгана.

Хүснэгт 17. Хүүхдийн эмийн тун

Эмийн нэр эмийн хэлбэр, тун)	(эмийн товчлол,	Тун	Хоногийн тун
Изониазид (H) (100мг шахмал)		4-6 мг/кг	300 мг
Рифампицин (R) (150 мг шахмал)		10-20 мг/кг	600 мг
Этамбутол (E) (100 мг шахмал)		15 мг/кг	1200 мг
Пиразинамид (Z) (400 мг шахмал)		30-40 мг/кг	2000 мг
Стрептомицин (S) (1г флакон)		20-40 мг/кг	1000 мг
Канамицин (Km) (1г флакон)		15-30 мг/кг	1000 мг
Амикацин (Am) (1г флакон)		15-20 мг/кг	1000 мг
Капреомицин (Cm) (1г флакон)		15-30 мг/кг	1000 мг
Офлаксацин (Ofx) (200 мг шахмал)		15-20 мг/кг	800 мг
Левифлоксацин (Lfx) (250 мг шахмал)		7.5-10 мг/кг	1000 мг
Моксифлоксацин (Mfx) (400 мг шахмал)		7.5-10 мг/кг	400 мг
Этионамид (Eto) (250 мг шахмал)		15-20 мг/кг	1000 мг
Протионамид (Pto) (250 мг шахмал)		15-20 мг/кг	1000 мг
Циклосерин (Cs) (250 мг капсул)		15-20 мг/кг	1000 мг
Теризидон (Trd) (300 мг шахмал)		10-20 мг/кг	1000 мг
Парааминосалицилийн хүчил (PAS) (4 гнунтаг, PASER)		150 мг/кг	8 гр
Клофазимин (Cfz)		1 мг/кг	100 мг
Линезолид (Lzd)		10-20 мг/кг	600 мг
Амоксициллин/клавуланат (Amx/Clv)		40 мг/кг	Өдөрт 2 удаа

Имипенем/силастатин (Ipm/ Cln)	25 мг/кг	25 мг/кг 2-3 удаа
Меропенем (Mpm)	40 мг/кг	Өдөрт 3 удаа
Кларитромицин (Clr)	7.5 мг/кг	Өдөрт 2 удаа
Изониазид, өндөр тунгаар (H)	16-20 мг/кг	Өдөрт 1 удаа

Хүснэгт 18. Нэг болон цөөн эмэнд тэсвэртэй сүрьеэгийн эмчилгээ

Эмэнд тэсвэржилтийн хэлбэр	Эмчилгээний горим*	Үргэлжлэх хугацаа (сараар)
H+E+S	H _{600mg} -R-E-Z	6-9

*Эмчилгээний 3 дахь сард түрхэц зэрэг бол ОЭТС-ийн эмчилгээний горимоор эмчилгээг эхэлнэ.

Хүснэгт 19. ОЭТС-ийн эмчилгээний горим

Эмэнд тэсвэржилтийн хэлбэр	Эмчилгээний горим	Үргэлжлэх хугацаа (сараар)
R	Z-E-S(Km)-Lfx-Eto-H	18-24
HR	Z-E-S(Km)-Lfx-Eto-H	
HRE	Z-S(Km)- Lfl-Eto-Cs-H	
HRS	Z-E-Km-Lfl-Eto(Cs)-H	
HRES	Z-Km(Cm)-Lfl-Eto(Pto)-Cs(PAS)-H	

Эрчимт шатны эмчилгээний хяналтын өсгөвөрлөх шинжилгээ дараалан 4 удаа сөрөг гарсан тохиолдолд тарилгыг хасаж үргэлжлэх шатанд шилжүүлнэ; хэрэв өсгөвөр сөрөгт шилжихгүй бол 8 дахь сарын өсгөвөрийн шинжилгээний хариуд үндэслэн тарилгын бэлдмэлийг хасна.

Эмчилгээний үр дүнгээс хамаарч тарилга, фторхинолоны бүлгийн эмийг сольж хэрэглэж болно. Горим бүрт изониазид өндөр тунтай (900мг) байна.

HRES, 2 дугаар эгнээний тарьж хэрэглэдэг аль нэг бэлдмэл эсвэл фторхинолоны бүлгийн аль нэг эмэнд тэсвэртэй нь тогтоогдсон тохиолдолд 3 дугаар эгнээний 5 дугаар бүлгийн эмнээс сонгож нэмэлтээр хэрэглэнэ.

Хүснэгт 20. МОЭТС-ийн эмчилгээний горим

Эмэнд тэсвэржилтийн хэлбэр	Эмчилгээний горим	Үргэлжлэх хугацаа (сар)
HRES, 2-эгнээний тарьж хэрэглэдэг аль нэг бэлдмэл, фторхинолоны бүлгийн аль нэг эм	Linezolid-Cfz- PAS-Z-Sm/Am/Km/Cm(Cs,Imp)-Mfx-өндөр тунтай Н	Эрчимт эмчилгээний шат 8-12 сар нийт 24 сар
	Linezolid-Cfz-Z- Bdq-Lfx- PAS-өндөр тунтай Н	
	Linezolid-Cfz-Z- OPC-Lfx- PAS- өндөр тунтай Н	

Хүснэгт 21. Өвөрмөц тохиолдлын эмчилгээний горим

Жирэмсэн эхчүүд	Жирэмснийг үргэлжлүүлэх асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлэнэ
	Аминогликозидын бүлгийн эм, Eth-ийг хэрэглэхгүй. Жирэмсний сүүлийн хагаст эмчилгээ эхлэх шаардлагатай тохиолдолд Z, Cm, Cs, OfI эмийн бэлдмэлүүдийг эмчийн хяналтан дор хэрэглэнэ
	Эмчилгээний явцад ба эмчилгээ дууссанаас хойш 2 жилийн хугацаанд жирэмслэхээс хамгаалах ерөндгийг тавиулахыг зөвлөнө
Чихрийн шижинтэй өвчтөн	Н Z, Eth, Pto FQ эмийн бэлдмэлүүдийг хэрэглэхдээ цусан дахь сахарын хэмжээг өдөр бүр 1-2 удаа шаардлагатай үед дотоод шүүрлийн эмчтэй хамтран хянаана
Сэтгэцийн өвчтөй	Cs-ийг хориглож PAS хэрэглэнэ, зайлшгүй тохиолдолд АНЭ болон сэтгэцийн эмчийн хяналтан дор эмчлүүлнэ
Элэгний хүнд хэлбэрийн эмгэгтэй өвчтөн	Элэгний эмгэгийн сэдрэл даамжирсан үед Eth, R, Н эмийн бэлдмэлүүдийг эмчийн хяналтан дор хэрэглэж, Z-ийг хэрэглэхийг хориглоно. Шинжилгээнд АЛАТ ,АСАТ ферментийн идэвхижил нь 3 дахин ихэссэн тохиолдолд эмийг түр зогсоож , 2 сарын дотор эмч нарын зөвлөгөөнөөр дахин оруулж шийдвэрлэнэ
Бөөрний дутагдалтай өвчтөнд	E, Cm, Eth, Cs эмийн бэлдмэлүүдийг эмчийн хяналтан дор хэрэглэх ба аминогликозидыг завсарлагаат ба бага тунгаар хэрэглэнэ
Сонсгол буурах эмгэгтэй өвчтөн	Сонсгол бууралтаас хамаарч түрхэц өсгөвөр сөрөгт шилжсэн тохиолдолд тарилгын бэлдмэлийг 7 хоногт 3-5 удаа завсарлагаат горимд шилжүүлж болно
бусад	Мэргэжлийн эмчийн зөвлөгөөг авч, хавсарсан өвчний эмчилгээг хийнэ

Хүснэгт 22. Эмэнд тэсвэртэй сүрьеэгийн эмийн гаж нөлөө, эмчилгээ

Сүрьеэгийн эм	Илрэх шинж	Авах арга хэмжээ
Cs, H, S, Km, Am, Cm, Eth/Pto, фторхинолоны бүлгийн эм	Захын мэдрэлийн эмгэг	Витамин B6 (100мг)-ийн тунг өдөрт 2 шахмал хүртэл ихэсгэж гаж нөлөө үзүүлж буй эмийн тунг бууруулах буюу хасна
S, Km, Am, Cm	Сонсгол муудах	45 наснаас дээш хүнд тарилгын бэлдмэлийн өдрийн тунг 250мг-аар бууруулж хэрэглэнэ.
Cs, H, фторхинолоны бүлгийн эмүүд	Таталт	Витамин B6 (100мг)-ийн тунг өдөрт 2 шахмал хүртэл ихэсгэж мэдрэлийн эмчийн зөвлөгөө авна
Cs, H, фторхинолоны бүлгийн эмүүд, Eth/Pto	Сэтгэцийн өөрчлөлт	Сэтгэцийн эмчийн зөвлөгөө авч гаж нөлөө үзүүлж буй эмийн тунг бууруулах буюу зогсооно
PAS, Eth/Pto	Гипотиреоз	Дотоод шүүрлийн эмчийн зөвлөгөө авна
Eth/Pto, PAS, H, E, Z	Дотор муухайрах	Шингэн сэлбэж бөөлжилтийн эсрэг эмээр эмчилж гаж нөлөө үзүүлж буй эмүүдийн тунг бууруулах буюу зогсооно
PAS, Eth/Pto	Ходоодны үрэвсэл	Антацид, H рецепторын хориг бэлдмэлүүд, бөөлжилтийн эсрэг эм хэрэглэж эмийн тунг бууруулах, 1-7 хоног зогсоох эсвэл бүр мөсөн зогсооно
Z, H, R, Eth/Pto, PAS, E, фторхинолоны бүлгийн эм	Элэгний үрэвсэл	Эмчилгээг зогсоох, элэгний үрэвсэл үүсгэж байгаа бусад шалтгааныг тогтоож элэг хамгаалах бэлдмэлүүд хэрэглэнэ
S, Km, Am, Cm	Бөөрний дутагдал	Гаж нөлөө үзүүлж байгаа бэлдмэлийг зогсооно
Cm, Km, Am, S	Электролитийн тэнцвэр алдагдах (цусан дахь кали ба магнийн хэмжээ буурах)	Шаардлагатай электролитийг нөхнө
E	Харааны өөрчлөлт	Эмийг зогсооно
Z, фторхинолоны бүлгийн эм	Үеэр өвдөх	Үрэвслийн эсрэг стероид бус бэлдмэлүүдийг хэрэглэнэ
Cs, H, фторхинолоны бүлгийн эм	Саажилт	Фенитоин, валпроны хүчил уулгана. Витамин B6 (100мг)-ийн тунг өдөрт 2 шахмал хүртэл ихэсгэж, нөлөөлж байгаа эмийн тунг бууруулах буюу хасч болно

Эмчилгээний хяналт

ЭТС-ийн эмчилгээний хяналтыг доорх үндсэн зорилгоор хийнэ:

- Эмчилгээний явцын үр дүн;
- Сүрьеэгийн эмийн гаж нөлөө;
- Эмчилгээ дууссаны дараа дахихаас сэргийлэх.



Эмчилгээний хяналтын шинжилгээ

- Цэрний өсгөврийн шинжилгээгээр эмчилгээний явцыг хянах ба эмчилгээний 2 дахь сард түрхэц болон өсгөвөр эерэг бол эмэнд мэдрэг чанар тодорхойлох шинжилгээ хийнэ
- Эмчилгээнд этионамид/протионамид, аминосалицилийн хүчил хэрэглэж байгаа үед цусан дахь бамбайн дааврын хэмжээг тодорхойлно
- Тарилгын бэлдмэл хэрэглэж байхад сонсголын бичлэг хийлгэхийг зөвлөнө
- Линезолид эсвэл Этамбутол >15 мг/кг хэрэглэж байхад нүдний харааг тогтмол шалгуулна.
- Бедакулин, фторхинолоны бүлгийн эмүүд болон Кларитромицин хэрэглэж байхад ЭКГ зайлшгүй хийнэ.
- Линезолид болон Кларитромицинаар эмчилж байхад үүсдэг цус багадалт ба цусанд тромбоцитийн тоог хянах зорилгоор ЦЕШ хийнэ

Хүснэгт 23. ЭТС-ийн хяналтын шинжилгээ

Хийгдэх шинжилгээ /уг зааврын 2 дугаар хавсралтын 2.1, 2.2 –ээс харах/	Эмчил-гээний эхэнд	2 дахь 7 хоног	хугацаа / сараар/																		
			1	2	3	4	5	6	7	8	10	12	14	16	18	20	24	28	32	38	44
Түрхцийн шинжилгээ /2.1/	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x
Өсгөвөрлөх шинжилгээ /2.2/	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x
Молекул биологийн шинжилгээ /2.3/	x																				
Эмэнд мэдрэг чанар тодорхойлох шинжилгээ /2.4/	x	x^{∞}				x^{∞}															
Цусны ерөнхий	x	x^a	x	x^a	x^a	x	x^a	x^a	x^a	x^a	x	x^a	x	x	x^a	x					
Биохими	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x		x		x					
Бамбайн дааврын	x		x^{Π}			x^{Π}					x^{Π}										
Гепатит В,С маркер	x																				
ХДХВ-г илрүүлэх	x					x					x					x		x	x	x	x
жирэмсний сорил	x																				
Биеийн өндөр	x																				
Биеийн жин	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x
сонсголын бичлэг	x	x^*	x^*	x^*	x^*	x^*	x^*	x^*	x^*												
хараа шалгах	x	x^{**}	x^{**}	x^{**}	x^{**}	x^{**}	x^{**}	x^{**}	x^{**}	x^*	x^{**}	x^{**}	x^{**}	x^{**}	x^{**}	x^{**}					
Рентген шинжилгээ	x		x			x					x					x		x			x
КТГ	x																				
ЭКГ	x	x																			

- x[∞]:** Түрхэц болон Өсгөвөр эмчилгээний 2 болон 6 дахь сард эерэг байгаа тохиолдолд
- x[†]:** эмчилгээнд Этионамид/протионамид, аминосалицилын хүчлийг эмчилгээнд хэрэглэж буй үед
- x^{*}:** 2-р эгнээний тарилгын бэлдмэлийг эмчилгээнд хэрэглэж буй үед
- x^{**}:** Линекезолид болон Этамбутолыг (>15mg/kg) эмчилгээнд хэрэглэж буй тохиолдолд өвчтөн КТГ хийлгэх боломжтой бол эмчилгээний явц үр дүнг хянахад илүү ач холбогдолтой
- x^a:** Линекезолид болон Кларитромицин эмчилгээнд хэрэглэж буй тохиолдолд цус багадалт болоод тромбоцитопени болохоос сэргийлж үзнэ

ЭТС-ийн эмчилгээний үр дүнг тооцох

Эдгэрсэн

Эмчилгээг бүрэн гүйцэд хийлгэсэн, эмчилгээ үр дүнгүй болсон нь нотлогдоогүй ба эрчимт шатны эмчилгээний дараа хамгийн багадаа 30 хоногийн зайтай дараалан хийсэн 5 ба түүнээс дээших өсгөврийн шинжилгээ сөрөг тохиолдол.

Эмчилгээ дуусгасан

Эмчилгээг бүрэн гүйцэд хийлгэсэн, эмчилгээ үр дүнгүй болсон нь нотлогдоогүй боловч эрчимт шатны эмчилгээний дараа хамгийн багадаа 30 хоногийн зайтай дараалан хийсэн 5 ба түүнээс дээших өсгөврийн шинжилгээ сөрөг болсон нь бүртгэгдээгүй тохиолдол.

Үр дүнгүй

Эмчилгээг зогсоосон, эсвэл дараах шалтгааны аль нэгний улмаас эмчилгээний горимд доод тал нь сүрьеэгийн эсрэг 2 эмийг солисон тохиолдол:

- Эрчимт шатны эмчилгээний төгсгөлд сөрөгт шилжээгүй
- Үргэлжлэх шатны эмчилгээний үед сөрөгт шилжсэний дараа нян судлалын шинжилгээгээр дахин эерэг болсон
- Фторхинолоны бүлэг эсвэл 2 дугаар эгнээний тарьж хэрэглэдэг эмэнд нэмэлтээр тэсвэртэй болох нь тогтоогдсон
- Эмийн гаж нөлөө илэрсэн

Хяналт алдагдсан

Эмчилгээний явцад 2 ба түүнээс дээш сарын хугацаанд эмчилгээ тасалсан

Нас баралт

Сүрьеэгийн улмаас нас барсан тохиолдол

Эмчилгээний үр дүн дүгнэгдээгүй

Эмчилгээний үр дүн тооцогдоогүй, өвчтөн шилжсэн тохиолдол.

5. Эмэнд тэсвэртэй сүрьеэгийн (ЭТС) халдвар хяналт

Өдрийн эмчилгээний цэгээр эмчлүүлж байгаа өвчтөнийг халдвартай, халдваргүйгээр нь тус тусдаа өрөөтэй байлгах, эсвэл цагийг зөрүүлэн тусламж, үйлчилгээг хүргэнэ.

Цэрний түрхэцийн болон өсгөвөрлөх шинжилгээ эерэг эмэнд тэсвэртэй сүрьеэтэй өвчтөнд эмчилгээ, үйлчилгээ үзүүлэх болон өвчтөний сорьцонд шинжилгээ хийх эмч, лаборант нар халдвар хяналтын дэглэмийг баримтлана.


ЭТС-тэй байж болзошгүй өвчтөнд цэрний өсгөвөрлөх шинжилгээний хариу 2 сар дараалан сөрөг болтол 1 удаагийн мэс заслын амны хаалт хэрэглүүлж, цэрийг зориулалтын саванд цуглуулж, өдөр бүр халдваргүйтгэлийн бодисоор халдваргүйтгэнэ.

ЭТС-тэй эмчлүүлэгчдийг эмэнд тэсвэржилтийн хэлбэрээр ангилан хэвтүүлнэ. Тасагт эмчлүүлж байгаа цэрний түрхэцийн болон өсгөвөрлөх шинжилгээ эерэг байгаа эмэнд тэсвэртэй сүрьеэтэй өвчтөнд эм уулгах, хоол, цай өгөх, тусламж үйлчилгээ үзүүлэх бүхий л төрлийн үйл ажиллагааг тухайн өвчтөн хэвтэн эмчлүүлж байгаа өрөөнд хийнэ.

6. Эмэнд тэсвэртэй сүрьеэтэй (ЭТС) өвчтөнг бүртгэх, мэдээлэх

- Сүрьеэгийн эмч ЭТС-ийн сэжигтэй тохиолдлыг эмэнд тэсвэртэй сүрьеэ байж болзошгүй өвчтөний бүртгэл(ЭТС-15)-д бүртгэн сорьц цуглуулж эмэнд мэдрэг чанар тодорхойлох шинжилгээнд явуулах маягт (ЭТС-06)-ыг хамт ХӨСҮТ-ийн СТСА-ны лавлах лабораторид илгээнэ.
- Нян судлалаар болон эмнэлзүйгээр батлагдсан эмэнд тэсвэртэй сүрьеэгийн шинэ, дахилт, өмнө эмчлэгдсэн тохиолдлыг “Эмэнд тэсвэртэй сүрьеэтэй өвчтөний бүртгэл “(ЭТС-03)-д бүртгэн өвчтөн бүрт “Эмэнд тэсвэртэй сүрьеэтэй өвчтөний эмчилгээ хяналтын карт “ (ЭТС-01) нээнэ.
- Өвчтөн эмчилгээний хугацаанд шилжсэн тохиолдолд “Өвчтөнг шилжүүлсэн мэдээ” (ЭТС-09)-г 3 хувь бичиж өвчтөн, эмчилгээг үргэлжлүүлэх эрүүл мэндийн байгууллага, Сүрьеэгийн тандалт судалгааны албанд тус тус өгнө
- Сүрьеэгийн бүртгэгдсэн тохиолдол болон бусад улирлын тайланг тухайн улирлын сүүлийн сарын сүүлийн өдрөөр тасалбар болгон дараах сарын эхний 7 хоногт багтааж сүрьеэгийн кабинет болон тасгийн эмчээр хянуулан ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн тандалт судалгааны албанд илгээнэ.

Эрүүл мэндийн сайдын 2014 оны
09 сарын 26 өдрийн 319 дугаар
тушаалын 4 дүгээр хавсралт



СҮРЬЕЭ, ХДХВ/ДОХ-ЫН ХАВСАРСАН ХАЛДВАРЫН ҮЕИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗААВАР

1. Тодорхойлолт, нэр томьёо

ХДХВ-ийн халдвартай сүрьеэтэй өвчтөн:

Сүрьеэгийн эмчилгээний өмнө эсвэл явцад ХДХВ-ийн халдвартай нь тогтоогдсон үйлчлүүлэгч

ХДХВ-ийн халдваргүй сүрьеэтэй өвчтөн:

Сүрьеэгийн эмчилгээний өмнө эсвэл явцад ХДХВ-ийн халдваргүй нь тогтоогдсон

ХДХВ-ийн халдвартай эсэх нь тодорхойгүй сүрьеэтэй өвчтөн:

ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээнд хамрагдаагүй буюу шинжилгээний үр дүн тодорхойгүй тохиолдол

Үйлчилгээ үзүүлэгчийн санаачилгаар хийгдэх шинжилгээ:

Эмч, эмнэлгийн мэргэжилтэн ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээний талаарх мэдээлэл үйлчлүүлэгчдэд өгч зөвшөөрөл авсны үндсэн дээр ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээнд илгээх, хариу гарсны дараа давтан зөвлөгөө өгөх, шаардлагатай тохиолдолд тусламж үйлчилгээ үзүүлэхийг хэлнэ

2. Сүрьеэтэй өвчтөнд ХДХВ-ийн халдвар илрүүлэх


Сүрьеэтэй нь оношлогдож бүртгэгдсэн дараах тохиолдолд үйлчилгээ үзүүлэгчийн санаачилгаар ХДХВ-ын халдвар илрүүлэх үзлэг шинжилгээг заавал хийнэ

- Шинээр бүртгэгдсэн сүрьеэгийн тохиолдол />16 нас/
- Давтан бүртгэгдсэн сүрьеэгийн тохиолдол />16 нас/
- Эмэнд тэсвэртэй сүрьеэгийн бүртгэгдсэн тохиолдол 6 сар тутам />16 нас/
- Сүрьеэгийн эмчилгээ хийлгэж байгаа өвчтөнд ХДХВ-ийн халдварын шинж тэмдэг илрэх үед (ХДХВ/ДОХ/БЗДХ-ын оношлогоо эмчилгээний зааврын ХДХВ халдварыг сэжиглэх шинж тэмдгүүд)

Сүрьеэтэй өвчтөнийг ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээнд хамруулахдаа дараах журмыг баримтална

- Сүрьеэгийн бүртгэгдсэн тохиолдол бүрийг оношилсон сүрьеэгийн эмч ХДХВ илрүүлэх шинжилгээнд хамруулна
- ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээнд хамрагдах хүмүүст ХДХВ, ДОХ-ын тухай болон ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээний талаарх мэдээллийн хуудсыг уншуулан танилцуулж, ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээнд хамрагдах зөвшөөрлийг амаар авна.

- ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээний бичгийг тухайн үйлчлүүлэгчид өгч өвчтөнөө лаборатори луу илгээнэ.
- Шинжилгээний хариу “сөрөг” гарсан тохиолдолд шинжилгээний дараах зөвлөгөө өгсний үндсэн дээр үйлчлүүлэгчдэд шинжилгээний хариуг шууд өгнө.
- Шинжилгээний хариу “эерэг” гарсан тохиолдолд БЗДХ/ХДХВ/ДОХ-ийн тусламж үйлчилгээний зааварт заасны дагуу мэргэжлийн эмчийн хяналтанд шилжүүлж хавсарсан халдварын хяналтанд авна.



3. ХДХВ/ДОХ-той өвчтөнд сүрьеэ илрүүлэх

Рентген шинжилгээ, түрхцийн шинжилгээ (флюоросцент), өсгөвөрлөх шинжилгээ, молекул биологийн шинжилгээ, гистологи шинжилгээний аргуудыг ашиглана

Бүлэг 4. Сүрьеэ, ХДХВ/ДОХ-ын хавсарсан халдварын эмнэл зүй


Сүрьеэ, ХДХВ/ДОХ-ын хавсарсан халдварын үе дэх уушгины сүрьеэгийн эмнэл зүй

- ХДХВ-ийн халдварын эрт үед сүрьеэ ердийн байдлаар илэрч, голдуу уушигны дээд дэлбэнд өөрчлөлт үүснэ.
- Дархлалын хомсдол гүнзгийрэх тусам анхдагч сүрьеэ, уушгины бус эрхтэний болон тархмал сүрьеэтэй төстэй шинжүүд илэрч уушгины угийн тунгалгийн булчирхай, уушгины доод дэлбэн гэмтдэг.
- Сүрьеэ, ХДХВ/ДОХ-ын хавсарсан халдвартай өвчтөнд халуурах, биеийн жин буурах, хөлрөх шинжүүд элбэг тохиолдоно. ХДХВ/ДОХ-ын халдвартай өвчтөний эсийн дархлал буурсантай холбоотой гуурсан хоолойн доторх цочрол бага байдгаас ханиалгах шинж бага илэрнэ.
- ХДХВ-ийн халдвартай СД4 эсийн хэмжээ 200 эс/мм^3 -аас дээш үед сүрьеэтэй өвчтөнд эмнэлзүй болон рентген шинжилгээний өөрчлөлт ХДХВ-ийн халдваргүй хүнтэй ижил илэрнэ. Харин СД4 эсийн хэмжээ 200 эс/мм^3 -аас бага үед уушигны сүрьеэгийн хэв шинжит бус эмнэлзүйн шинж тэмдгүүд илэрнэ.

Сүрьеэ, ХДХВ/ДОХ-ын хавсарсан халдварын үе дэх уушгины бус эрхтэний сүрьеэгийн эмнэл зүй

- Сүрьеэ ХДХВ/ДОХ-ын хавсарсан халдвартай өвчтөнд уушгины бус эрхтэний сүрьеэгийн хэлбэр зонхилон тохиолддог байна.
- Тухайн эрхтэний өөрчлөлттэй холбоотой эмнэл зүйн шинжээс гадна халуурах, хөлрөх, биеийн жин алдагдах зэрэг шинж тэмдэг илэрнэ.

Бүдүүвч 9. ХДХВ/ДОХ-ын халдвартай хүнд сүрьеэг оношлох



Бүлэг 5. Бүртгэн мэдээлэх

- Сүрьеэтэй өвчтөн ХДХВ/ДОХ-ын халдвартай нь тогтоогдсон тохиолдол бүрийг ХДХВ/ДОХ-ийн мэдээлэх журмын дагуу ХӨСҮТ-д мэдээлнэ.
- Оношийн хариуг кабинетэд ТВ 01, клиникт 13 маягтын ард бүртгэн сүрьеэгийн эмчийн хяналтад шилжүүлнэ.


Бүдүүвч 10. Сүрьеэтэй өвчтөнд ХДХВ/ДОХ илрүүлэх



Бүлэг 6. Эмчилгээ

Сүрьеэтэй өвчтөн ХДХВ/ДОХ-той болох нь тогтоогдсон үед котримоксазолын урьдчилан сэргийлэх эмчилгээ болон РВЭЭ-г "ХДХВ/ДОХ/БЗДХ-ын эмч тусламж үйлчилгээний зааврын дагуу хийнэ.

Сүрьеэтэй өвчтөний сүрьеэгийн эмчилгээг харъяа эрүүл мэндийн байгууллагын сүрьеэгийн эмч тусламж үйлчилгээний зааврын дагуу хийнэ.



Бүлэг 7. Хавьтлын урьдчилан сэргийлэх эмчилгээ

Сүрьеэтэй нь батлагдаагүй ХДХВ/ДОХ-ын халдвартай хүнийг урьдчилан сэргийлэх изониазид эмчилгээнд хамруулна. Хоногийн тун 300 мг, 6 сар эмчилнэ.

ХДХВ/ДОХ-ын халдвартай нь тогтоогдсон боловч сүрьеэгээр өвчлөөгүй эсвэл ХДХВ/ДОХ-ын халдвартай, өмнө нь сүрьеэгээр өвчилсөн боловч бүрэн эдгэрсэн өвчтөнийг амьдралын туршид нь нэг удаа изониазидийн урьдчилан сэргийлэх эмчилгээнд оруулах ба хоногийн тун 300 мг, 6-9 сар үргэлжилнэ

Түрхэц эерэг эмэнд мэдрэг болон тэсвэртэй сүрьеэтэй өвчтөний хавьтал, сүрьеэтэй нь батлагдаагүй, ХДХВ/ДОХ-ын халдвартай хүнийг 5 жил хүртэл сүрьеэгийн эмчийн хяналтанд авна.